



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН АУТЕНТИК ТАЙЛБАРТАЙ
ЗАРИМ ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР
ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**
(Хулгайлах гэмт хэргийн эрх зүйн зохицуулалт,
тулгамдаж буй асуудал)

2022

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Судалгааны захиалагч:

Хууль зүйн үндэсний хүрээлэн

Судалгааг удирдсан:

Т.Золбоо

МУИС-Хууль зүйн сургуулийн багш
Хууль зүйн ухааны магистр (LL.M)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Ариунжаргал

Хуульч
Хууль зүйн ухааны магистр (LL.M)

Б.Мөнгөншагай

МУИС-Хууль зүйн сургуулийн дадлагажигч багш
Хууль зүйн ухааны магистр (LL.M)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
МУГХУСАЗЗ	Монгол Улсын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
УИХТГ	Улсын Их Хурлын тамгын газар
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЗЯ	Хууль зүйн яам
ШЯЯ	Шүүх явдлын яам
ЭХХШТХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

УДИРТГАЛ	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ	ҮЕ
ШАТ.....	5
1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох	5-6
1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох	6-7
1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох	7-9
1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох.....	10
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох.....	10
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.....	10
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	10-12
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ.....	13
3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал ..	13-20
3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал.....	20-36
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	37
4.1. ДҮГНЭЛТ.....	3
7	
4.2. ЗӨВЛӨМЖ.....	3
9	
ТАВ. СУДАЛГААНЫ ЭХ СУРВАЛЖ.....	39-40
ХАВСРАЛТ	

УДИРТГАЛ

2002 оны Эрүүгийн хуулийг баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шаардлагаас шалтгаалан уг хуульд 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж салбарын олон эрдэмтэн, судлаачид үзсэнээр 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулсан.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж¹ улмаар Улсын Их хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх болсон билээ. Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад хуулийг нэг мөр ойлгон хэрэглэх, хуулийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн ажлуудыг зохион байгуулж хэрэгжүүлж байгаа ч практикт хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтууд цөөнгүй байна. Тухайлбал, Эрүүгийн хуулийн аутентик тайлбар бүхий зохицуулалтуудаас хамгийн их асуудал дагуулж буй зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг юм.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан Хулгайлах гэмт хэрэг нь бусад гэмт хэрэгтэй харьцуулахад практикт түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг болохын хувьд тус зохицуулалт нь эрх зүйн хийдэлтэй байх нь эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг, ялын бодлого, хуулийн зохицуулалтын уялдаа холбоо, эрх зүйн зарчим, хуулийн зорилго алдагдахад хүрэх эрсдэлтэй. Иймд Эрүүгийн хуулийн аутентик тайлбартай зарим зохицуулалтыг судлан үзэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байсан тул Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захиалгаар энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн болно.

Энэхүү судалгааны зорилго нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд тусгасан аутентик тайлбар, түүний ач холбогдол, онцлог, онолын ойлголт, эл ойлголтын түүхэн уламжлал, гадаадын зарим орны туршлагыг харьцуулан судлах, тус зохицуулалтыг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй асуудал, эрх зүйн хийдэл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

¹ ХЗЯ, Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, УБ, 2013.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хуулийн аутентик тайлбартай зарим зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж² улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд 4 жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид судлан үзэж өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байна.³

Тухайлбал, Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зарим зүйл заалтад аутентик тайлбар хийж, тухайн тайлбарыг шүүх хэрэг шийдвэрлэхдээ ашиглаж байна.

Хууль тогтоомж нь энгийн, тодорхой, ухаалаг байх ерөнхий шаардлагатай боловч батлагдсан хууль зарим тохиолдолд давхардал, хийдэл, алдаа, зөрчил, салаа утгатай зохицуулалт зэргээс үүдэн хэрэглэхэд бэрхшээлтэй байдал бий болдог. Үүнийг засч залруулах, нэг мөр ойлгож хэрэглэхэд эрх зүйн цагаан толгойн нэг хэсэг нь болсон эрх зүйн тайлбар чухал үүрэгтэй.⁴ Эрх зүйн хэм хэмжээг тайлбарлах аутентик тайлбар нь албан ёсны тайлбарын нэг төрөл⁵ бөгөөд заавал биелэгдэх шинжийг агуулж байдаг.

² ХЗЯ, Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, Уб, 2013.

³ Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэл, Д.Нямбатын Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ гэх мэт.

⁴ Д.Лүндээжанцан, “Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник”, Уб, 2016, 134 дэх тал

⁵ Т.Кашанина, “Хууль зүйн техник”, Уб, 2016, 348 дахь тал

Харин зарим зүйл заалтын хувьд тухайн заалтын бүрэлдэхүүн нь аутентик тайлбартаа үндсэн бүрэлдэхүүнээсээ өөрөөр хэрэглэгдэхээр байгаа нь хуулийн нэг мөр ойлгож, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулж болохуйц байгаа учир тухайн заалтуудыг практикт нэг мөр хэрэгжүүлэхийн тулд энэ мэт зохицуулалтад үнэлгээ хийх шаардлага үүссэн гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн зүйл, заалтад хууль тогтоогч аутентик тайлбар хийж өгснөөр тус зүйл, заалтыг практикт хэрэгжүүлэх, хууль хэрэглээ хийгээд гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, учирсан хохирол, ялын бодлого зэрэг нь өөр хоорондоо уялдаагүй, зарим тохиолдолд зөрчилдөх явдал цөөнгүй байна. Тухайлбал, маргаан бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт *“...Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй...”* гэж заасан нь практикт хэд хэдэн асуудлыг бий болгож байна.

Дээрх тайлбартай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бага хэмжээний хохирлоос⁶ дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардахгүй байгаа юм. Уг асуудалд салбарын эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, прокурор, шүүгчид өөр өөр байр суурийг илэрхийлж байна. Тухайлбал, зарим судлаачид⁷ хуулийн дээрх зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу үндсэн бүрэлдэхүүндээ бага хэмжээнээс дээш хохирол шаардаж байгаа хэрнээ хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг зөрчиж байна хэмээн үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор практикт маргаан дагуулаад байгаа Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг болон Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтад үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн гэж үзлээ. Иймд энэхүү үнэлгээгээр дээр дурдсан зохицуулалт болон Эрүүгийн хуулийн аутентик тайлбар бүхий зарим зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

⁶ Эрүүгийн хууль, 2.5 дугаар зүйл, 4.3 дахь заалт “бага хэмжээний хохирол” гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээ

⁷ Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, нар “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэлдээ, Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ, Б.Ганболд “Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай)” нийтлэлдээ тус тус дурдсан байна.

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийхэд ихээхэн цаг хугацаа, хөдөлмөр, зардал шаардагдана. Иймд хуулийн зорилгыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөлөл үзүүлэх зарим зохицуулалтыг тусгайлан сонгож үнэлгээ хийх нь илүү үр дүнтэй байдаг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн онцлог нь хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд насанд хүрсэн хүнээс ялгамжтай байдлаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж, ялын агуулга хэлбэрийг шинэчлэн тодорхойлж, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасан явдал юм.⁸

Иймд энэхүү судалгаагаар Эрүүгийн хуулийн аутентик тайлбар бүхий зохицуулалтуудаас практикт түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэг болох Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь дээрх онцлог шинжийг хангасан эсэх, аутентик тайлбарын ойлгомжтой, оновчтой байдал, хууль хэрэглэхэд гарч буй эерэг, сөрөг талыг судалж эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол...” хэмээн Хулгайлах гэмт хэргийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй байхаар хуульчилсан боловч тайлбар хэсэгт “...Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцоггүй...” гэж зааснаас үзвэл энэхүү гэмт хэргийг материаллаг бүрэлдэхүүнтэй болгон аутентик тайлбар хийжээ. Энэ нь хуулийг тайлбарлан хэрэглэх эрх зүйн онол, хэвшин тогтсон практик, уламжлалт ойлголтод нийцэхгүй байна.

Түүнчлэн, Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй

⁸ ХЗДХЯ, Сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ, 2017, 4 дэх тал.

байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс үзвэл, Эрүүгийн хуулийн үндсэн зорилгын нэг нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтын нэг болох Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйл	<p>1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>2.Энэ гэмт хэргийг:</p> <p>2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;</p> <p>2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;</p> <p>2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;</p> <p>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;</p> <p>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь Эрүүгийн хуулийн тулгамдаж буй асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогдож байна. Учир нь энэхүү тайлбарт “...Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй...” гэж заасан нь судлаачдын дунд ихээхэн маргаан дагуулсаар байна. Учир нь бага хэмжээний хохирол учруулж, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд ялын хувьд сонгох санцгүйгээр 2-8 жилийн хорих, 5-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь энэ гэмт хэргийн улмаас бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүний хувьд эрх зүйн байдал нь дордож, хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирохгүй байна гэж зарим судлаачид⁹ үзэж байна.

Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйл	1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

⁹ Г.Ганбаатар, Б.Ганболд, Ж.Эрдэнэбулган, Эдгээр судлаачдын нийтлэл, бүтээлүүдийг энэхүү судалгаанд ашигласан болно.

		<p>2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>3.Энэ гэмт хэргийг:</p> <p>3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;</p> <p>3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.</p> <p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>
--	--	--

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш;
- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хуулиас сонгон авсан зохицуулалтыг өмнөх хууль тогтоомж дахь заалттай харьцуулан авч үзэх хэлбэрийг ашиглана.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эрүүгийн хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараахь таамаглал дэвшүүлж, асуулт боловсрууллаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2016 онд баталсан “Аргачлал батлах тухай” 59 дүгээр тогтоолын хавсралт 6

буюу Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.7.3-т заасан дүн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээллийг цуглуулах аргуудыг дагуу баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг унших, судлах, харьцуулалт хийх, эх сурвалж, баримт мэдээллийг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх болон тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, кейс судалгааны арга зүйг ашигласан болно.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Энэхүү судалгааг хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1987 он;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль (1971 оны 03-р сарыг дуустал гарсан нэмэлт, өөчлөлтүүдийг оруулав), 1971 он;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, ШЯЯ, 1949 он;

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Д.Лүндээжанцан, Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник, 2016 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСА33, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСА33, 2018 он
- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;

- Монгол Улсын Эрүүгийн Хууль, Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх Хууль (Монгол Улсын Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбарууд), ХЗЯ, 1995 он;
- Парлементтын судалгааны эмхэтгэл 21 боть. УИХТГ, Парламентын судалгааны хүрээлэн
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Т.Кашанина, Хууль зүйн техник, 2016 он;
- Үндсэн хуулийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2011 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” нийтлэл, 2017 он.

Цахим эх сурвалж

- Basic Law of the Federal Republic of Germany. Available at. <https://www.bundestag.de>
- [Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.](#)
- [Legalinfo.mn, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем;](#)
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Конституция рф. Глава 7.статья 126. Available at. <https://constitutionrf.ru/rzd-1/gl-7/st-126-krf>

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл буюу түүний тайлбарыг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Эрүүгийн хуулийн зорилтыг зорилго хэмээн өөрчилсөн бөгөөд гэмт халдлагаас хамгаалахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулахаар заасан.¹⁰

Эрүүгийн хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” хэмээн 1.1 дүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томъёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

Үнэлгээ:

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт Монгол Улсын иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан үндсэн эрх, эрх чөлөө хамаарна.¹¹

Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах нэгэн баталгаа нь Эрүүгийн хууль бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэдэг. Энэ ч утгаараа Эрүүгийн хууль нь бусад хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байдаг хатуу хууль юм.

Тиймээс ч Эрүүгийн хууль нь хүний амьдрах эрх, аюулгүй байдал, амин эрх ашиг, үнэт зүйлсийн үндсэн бөгөөд онцгой хамгаалалт учир Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт нь орчин цагийн эрх зүйн хөгжлийн түгээмэл хандлага, нийгмийн бодит амьдрал ахуйд нийцсэн, зөв оновчтой, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, эрх зүйн хийдэлгүй байх зэрэг “олон талт” шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.¹²

¹⁰ ХЗДХЯ, Сургагч багш нарт зориулсан гарын авлага, УБ, 2017, 5 дахь тал.

¹¹ Мөн тэнд.

¹² Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг нийтлэл, 2017.

2002 оны Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах болсон нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томьёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд¹³ чиглэсэн.

Хуулийн тайлбарыг тодорхой субъектүүд хийнэ.¹⁴ Монгол Улсын хувьд Монгол Улсын Үндсэн хуулийн¹⁵ Тавьдугаар зүйлийн 50.1.4 дээх заалтад Монгол Улсын Дээд шүүх нь “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” бүрэн эрхийг хэрэгжүүлнэ хэмээн заасан байдаг билээ. Үндсэн хуулийн эл зохицуулалтыг 1993 он, 2002 оны Шүүхийн тухай хуулиудаар УДШ-ийн нийт шүүгчдийн хуралдаанаар тогтоол гарган буюу хэрэг, маргаанаас гадуур (абстракт байдлаар) хууль тайлбарлахаар зохицуулж ирэв.¹⁶ Ийнхүү Улсын дээд шүүх нийт шүүгчдийн хуралдаанаар буюу абстракт байдлаар хууль тайлбарлах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ хэмээн тусгагдсаны дагуу Улсын дээд шүүхээс ч хууль тайлбарласан тогтоолуудыг идэвхтэй гаргаж ирэв.¹⁷ Тухайлбал, албан бус статистик тоо баримтаас харахад УДШ 1993 оноос одоо болтол 20 жилийн хугацаанд хуулийн заалтыг тайлбарласан 200 гаруй тогтоол гаргаж байсан байна.¹⁸ Эдгээрээс 2002 оны Эрүүгийн хуулийг тайлбарласан 12 тогтоол гаргасан байх бөгөөд одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2015 оны Эрүүгийн хуульд Улсын дээд шүүхээс тайлбарласан тогтоол гараагүй байгаа юм.

Хууль тайлбарлаж буй субъектээс буюу үйлчлэх хууль зүйн хүчийн чадлаас хамааруулан эрх зүйн тайлбарыг албан ёсны тайлбар, албан бус тайлбар гэж ангилан үздэг. Албан ёсны тайлбарыг хэм хэмжээний, казуаль тайлбар гэж ангилан авч үздэг

¹³ ХЗЯ, Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, УБ, 2013.

¹⁴ Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник, УБ, 2016, 143 дах тал

¹⁵ Монгол Улсын Үндсэн хууль, Тавьдугаар зүйлийн 50.1.4 дээх заалт, УБ, 1992.

¹⁶ 1993 оны Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6 дэх хэсгийн 24.6.6 дахь заалтад “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах. Улсын дээд шүүхийн тайлбарыг тухайн хуулийг хэрэглэж байгаа хүн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө”, 55 дугаар зүйлд “Улсын дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад хууль зүйн онолын асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн тоо бүртгэл, практикийг нэгтгэн дүгнэж санал гаргах үүрэг бүхий шүүхийн судалгааны төв ажиллана” хэмээн заасан байв. 2002 оны Шүүхийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 15.6.5-д заасны дагуу Үндсэн хуулиас бусад хуулийн заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбарыг Улсын дээд шүүх гаргана”, 23.2 дахь хэсэгт “Иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага хуулийг ойлгох, дагаж мөрдөх, хэрэгжүүлэх, хэрэглэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа Улсын дээд шүүхэд ирүүлнэ”, 23.4 дэх хэсэгт Анхан, давж заалдах, хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн шүүх хуралдаанаар хэрэг маргааныг хянан шийдвэрлэх явцад гарсан эргэлзээтэй, салаа утгаар ойлгож болох заалтыг тайлбарлуулах тухай саналаа талуудын гаргасан тайлбар, үндэслэлийн хамт Улсын дээд шүүхэд ирүүлж болно”, 23.7 дахь хэсэгт “Хуулийн тайлбарыг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа иргэн, албан тушаалтан, аж ахуйн нэгж, байгууллага дагаж мөрдөнө” хэмээн зохицуулж байв. Тус хуулийн зохицуулалтын дагуу Улсын дээд шүүхийн дэргэд шүүхээс хууль хэрэглэх, тайлбарлахад эрх зүйн онол, практикийн асуудлаар зөвлөмж өгөх, шүүхийн статистик, практикийг нэгтгэн судалж санал дүгнэлт гаргах үүрэг бүхий судалгааны төв ажиллаж байв.

¹⁷ А. Базар, “Улсын дээд шүүхээс хууль тайлбарлах, хуулийг нэг мөр, зөв хэрэглээг хангах асуудал” Эрдэм шинжилгээний илтгэл, УБ, 2015,

¹⁸ УДШ, УДШ-ийн тогтоолуудын эмхэтгэл, УБ, 2013.

бөгөөд хэм хэмжээний тайлбарыг аутент буюу эх тайлбар, легаль буюу зөвшөөрөгдсөн гэсэн дэд хэсгүүдэд хуваадаг.¹⁹

Аутентик тайлбар нь албан ёсны тайлбарын нэг төрөл бөгөөд эрх зүйн хэм хэмжээг батлан гаргадаг байгууллагаас гаргасан тайлбар. Аутентик тайлбарыг 1987 оны Эрүүгийн хууль, 1995 оны Эрүүгийн хууль, 2002 оны эрүүгийн хууль, 2015 оны эрүүгийн хуулиудад хийсээр ирсэн байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт маргаан дагуулаад буй асуудлын нэг нь 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн тайлбар хэсэг юм. Уг тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заажээ.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбарыг судлаачид өөр өөрийн үзэл бодлоор тайлбарлаж байна. Тухайлбал, судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ “...Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь “Зорилго чиглэл, утга агуулга”-ын хувьд гагцхүү Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шууд хамааралтайгаар хуульчлагдсан, тухайн хамаарах хэсгийн хэм хэмжээний хамт хүчин чадалтай байх хэдий боловч тухайн тайлбар дахь “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг “тайлбар” гэж үзэх боломжгүй харин эсрэгээр тайлбарт хамаарахгүй өөр зохицуулалтыг тусгасан нь хуулийн тухайн зүйлийн хэсгүүд хооронд зөрчилдөөн үүсгэж, улмаар иргэдийг хуучин Эрүүгийн хуулиас илүүтэй шоронжуулахад чиглэсэн үзэл санааг агуулсан нь илэрхий байна...” хэмээн үзжээ.

Онолын үүднээс авч үзвэл, эрх зүйн хэм хэмжээний албан ёсны тайлбар нь кейсийн тайлбар болон хэм хэмжээний тайлбар гэсэн хоёр төрөлтэй байдаг. Эрх зүйн хэм хэмжээний буюу норматив тайлбар нь аутентик тайлбар ба хууль зүйн тайлбарт /УДШ-ийн абстракт тайлбар/ хуваагдана. Тэрээр Аутентик тайлбарыг тодорхойлохдоо эрх зүйн хэм, хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарласан тайлбар. Эрх зүйн хэм хэмжээний утга санааг шууд тайлбарлахад чиглэгдэх хийгээд тэдгээрийг хэрэглэж байгаа бүхэнд заавал биелүүлэх шинжийг агуулдаг.²⁰

Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “...Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ...” хэмээн заасан байх бөгөөд дээрх зүйлийн тайлбар хэсэгт “...Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан

¹⁹ Мөн тэнд

²⁰ С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), УБ, 2007, 648 дахь тал.

үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй...” гэж зааж өгсөн нь ямар нэгэн салаа утгагүйгээр хохирлын хэмжээнээс үл хамааран 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол 2 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 онд нийт 17734 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 14207 эрүүгийн хэрэг хүлээн авч 12551 хэрэг шийдвэрлэсэн харин 2019 онд нийт 18701 хүн, 10 хуулийн этгээдэд холбогдох 15126 эрүүгийн хэрэг хүлээн авснаас 1208 хүнд холбогдох 696 хэргийг прокурорт буцааж, 105 хүнд холбогдох 76 хэргийг түдгэлзүүлж, 252 хүнд холбогдох 130 хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, 1 хуулийн этгээд, 344 хүнд холбогдох 218 хэргийг хэрэгсэхгүй болгож, 106 хүнд холбогдох 57 хэргийг цагаатгаж, нийт 13427 эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэж, 15366 хүнийг гэм буруутайд тооцож, үүнээс 2167 хүнийг хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж, 36 хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, 13011 хүнийг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, ял шийтгэл оногдуулсан бөгөөд тайлант хугацааны эцэст 887 хэргийн үлдэгдэлтэй байна²¹.

Харин 2020 онд эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр нийт 13470 хэрэг шийдвэрлэгдснээс 1614 буюу нийт хэргийн 11,98 хувь, 2021 оны эхний хагас жилийн байдлаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс шийдвэрлэгдсэн нийт 5824 хэргийн 573 буюу 9,83 хувийг хулгайлах гэмт хэрэг эзэлж байна.

Хүснэгт 3. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хулгайлах гэмт хэргийн тоон мэдээ

Он	2018 он ²²	2019 он ²³	2020 он ²⁴	2021 он эхний хагас жил ²⁵
Нийт шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоо	12551	13427	13470	5824
Хулгайлах гэмт хэрэг	1553	1671	1614	573

Харин 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх үед хулгайлах гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэж байсан тоон мэдээг харвал 2011 онд 1282, 2012 онд 1281, 2013

²¹ Монгол Улсын шүүхийн тайлан, 2019, <https://www.court.za.gov.mn/812--2019-.html>

²² Монгол Улсын шүүхийн 2018 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны тайлан, <http://www.judinstitute.mn/main/236--2018-.html>

²³ Монгол Улсын шүүхийн тайлан, 2019, <https://www.court.za.gov.mn/812--2019-.html>

²⁴ Монгол Улсын шүүхийн тайлан 2020, https://admincourt2.gov.mn/site/full_story/2339

²⁵ Монгол Улсын шүүхийн 2021 оны эхний хагас жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ, <https://court26.kho.gov.mn/news/619--2021-.html>

онд 1283, 2014 онд 1336, 2015 онд 1418²⁶, 2016 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар 995 хэргийг тус тус шийдвэрлэж байжээ. Гэхдээ 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэгт мал хулгайлах гэмт хэрэгт хамаарч байсныг анхааран үзэх нь зүйтэй. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар “Мал хулгайлах” гэмт хэргийг тусад нь бие даасан гэмт хэрэг байхаар шинээр хуульчилж өгсөн.

Ийнхүү хулгайлах гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өсөж буй нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбартай хамаарал бүхий байж болох юм.

Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь бусдын “хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар...” авсан үйлдэл байх бөгөөд энэхүү үйлдлийн улмаас бага хэмжээнээс²⁷ дээш буюу 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулахаар хуульчилжээ.

Гэтэл энэ зүйлийн тайлбар хэсэгт “...Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй...” гэж заасан байна. Дээрх тайлбараас үүдэн хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж үйлдсэн тохиолдолд ч эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байгаа юм.

2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан, харин хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдол хохирол шаардахгүй байдлаар хуульчилснаараа өмнөх хуулиас нэлээд ялгаатай зохицуулалт болсон байна.

Түүнчлэн, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас хамааран Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүнд оногдуулах хорих ял нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд “...тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

²⁶ Монгол улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл, Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2016, Уб, 2017, 152 дахь тал.

²⁷ Эрүүгийн хууль, 2.5 дугаар зүйл, 4.3-т “бага хэмжээний хохирол гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг”, мөн хуулийн 5.3 дугаар зүйл, 3 дахь хэсэгт зааснаар “...нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний хохирол нь 300.000 төгрөг бөгөөд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл, 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл нь 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардаж байгаа юм.

Тохиолдол 1.

Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 235 дугаар тогтоолтой иргэн А.М-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:²⁸

Шүүгдэгч А.М нь 2018 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Сэлэнгэ аймаг, Алтанбулаг сумын 1 дүгээр баг, Булгийн тоотод оршин суух Г.М-ийн гэрийн цонхоор нэвтрэн орж бэлнээр 50.000 төгрөг хулгайлсан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар шүүгдэгч А.М-д 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Тохиолдол 2.

Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын шүүхийн 2017 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 152 дугаар тогтоолтой иргэн Ш.Б-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:²⁹

Шүүгдэгч Ш.Б нь 2017 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 19-нд шилжих шөнө Сэлэнгэ аймаг Мандал сумын 9 дүгээр баг, Партизаны гудамжны холбооны агаарын шугамнаас ТПП100*2 маркийн 250 метр кабель утас хулгайлж 1.675.000 төгрөгийн, 2017 оны 05 дугаар сарын 20-ны өдрөөс 21-нд шилжих шөнө Сэлэнгэ аймаг Мандал сумын 9 дүгээр баг, Партизаны гудамжны эхний хөндлөн хэсгийн холбооны агаарын шугамнаас ТПП50*2 маркийн 350 метр кабель утас хулгайлж 1.365.000 төгрөгийн, 2017 оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс 09-нд шилжих шөнө Сэлэнгэ аймаг Мандал сумын 7 дугаар баг, Минжийнхангайн гудамжны 2 дахь хөндлөн хэсгийн холбооны агаарын шугамнаас ТПП20*2 маркийн 150 метр кабель утас хулгайлж 345.000 төгрөгийн, 2017 оны 07 дугаар сарын 10-ны өдрөөс 11-нд шилжих шөнө Сэлэнгэ аймаг Мандал сумын 9 дүгээр баг, Энхтайвны гудамжны холбооны агаарын шугамнаас ТПП50*2 маркийн 140 метр кабель утас хулгайлж 546.000 төгрөгийн, 2017 оны 07 дугаар сарын 14-ний өдрөөс 15-нд шилжих шөнө Сэлэнгэ аймаг Мандал сумын 9 дүгээр баг, Энхтайвны гудамжны холбооны агаарын шугамнаас ТПП30*2 маркийн 100 метр кабель утас хулгайлж 440.000 төгрөгийн, бүгд 4.371.000 төгрөгийн шууд хохирол, 2.203.680 төгрөгийн шууд бус хохирол, нийт 6.574.680 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс Ш.Б-г хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.Б-г 6 сарын хорих ялаар шийтгэсэн байна.

Дээрх 2 тохиолдолд шүүхээс ялгамжтай байдлаар ял оногдуулсан байх бөгөөд эхний тохиолдолд А.М нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй буюу хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч үйлдэн 50.000 төгрөгийн хохирол учруулж улмаар 1 жил хорих ялаар шийтгүүлсэн бол хоёр дахь тохиолдолд Ш.Б нь нийт 6.574.680 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт шүүхээс 6 сарын хорих ял оногдуулсан байна.

²⁸ Сэлэнгэ аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, Дугаар https://shuukh.mn/single_case/26642?daterange=2018-01-01%20-%202018-12-31&id=1&court_cat=2&bb=1

²⁹ Сэлэнгэ аймгийн мандал сум дахь сум дундш шүүхийн шийтгэх тогтоол, Дугаар 00152 https://shuukh.mn/single_case/14766?daterange=2017-01-01%20-%202018-12-22&id=1&court_cat=2&bb=1

Өөрөөр хэлбэл, учруулсан хохирлын хэмжээний хувьд 1 жилийн хорих ял шийтгүүлсэн А.М нь 50.000 төгрөг буюу бага хэмжээний хохирол, 6 сарын хорих ял шийтгүүлсэн Ш.Б нь 1.660.000 төгрөгийн хохирлыг бусдад учруулсан байна.

Товчхондоо хохирлын хэмжээ их байх тусмаа тухайн хүнд оногдуулах ялын хэмжээ нэмэгдэх нь зүйн хэрэг. Гэтэл бусдад 50.000 төгрөгийн хохирол учруулснаа төлөө 1 жил чөлөөгөө хасуулан эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд төрөл болох хорих ялаар шийтгүүлж байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-д нийцэж буй эсэх нь эргэлзээтэй юм. Түүнчлэн, дээрх хоёр тохиолдол нь гэмт хэргийн ангиллын хувьд ч эрс ялгаатай байна.

Гэмт хэрэг бүрт нийгэмд аюултай байдлын шинж чанар, хэр хэмжээ оногдуулж болох ялын хүнд, хөнгөн зэрэг шалгууруудыг харгалзан нийт гэмт хэргүүдийг тодорхой төрөлд хуваахыг ангилалт гэнэ.³⁰

Гэмт хэргийн ангилал нь гэмт хэргийг нийгмийн хор аюул, шинж чанараар нь ангилахын зэрэгцээ хууль зүйн үр дагаврыг ангиллаас нь хамааран ялгамжтайгаар тогтоох, эрүүгийн хариуцлагыг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй хууль зүйн техникийн хувьд ерөнхий ангид заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд чухал ач холбогдолтой тул гэмт хэргийг хөнгөн, хүнд гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан.³¹

Дээрх тохиолдолд 51.250 төгрөгийн хохирол бусдад учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд хүнд гэмт хэрэгт хамаарна. Харин 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

Нөгөөтээгүүр хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлан өгсөн. Тухайлбал, дээрх 2 тохиолдолд А.М нь хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч эд зүйл хулгайлсан учир хүндрүүлэн авч үзэж буй нь зүйн хэрэг боловч хохирлын хэмжээ нь 50.000 төгрөг байгаа нь хулгайлах гэмт хэргийнхээ үндсэн бүрэлдэхүүнийг хангаагүй (17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй) байхад хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн учраас бага хэмжээний хохирол учруулсан ч хүндрүүлэн зүйлчилж байгаа нь өрөөсгөл юм.

Учир нь эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх зэргээр тайлбарлан хэрэглэж ирсэн байдаг ба үндсэн бүрэлдэхүүний

³⁰ С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол I боть, Уб, 2009, 206 дахь тал.

³¹ ХЗДХЯ, Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга.

шинжгүй нөхцөлд дараахь хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж бий болохгүй гэсэн үзэл хэвшин тогтсон ойлголт.³²

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн тайлбар нь дээрх ойлголттой зөрчилдөж байна.

Хуулийн энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалахад чиглэж буй хэдий ч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар хандаж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирлыг үл харгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зохицуулалтад нийцсэн эсэх нь эргэлзээ төрүүлэхүйц байна.

Мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн бөгөөд энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш хулгайлах төрлийн гэмт хэргийн гаралт, гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлж буй хүний тоо ч мөн өссөн үзүүлэлттэй байна. Иймд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо бүрэн хүрээгүй хэмээн үзэж байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах

1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тусгай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;

2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;

2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;

2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

³² Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018, №2, 61 дэх тал.

3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;

3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

Үнэлгээ:

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг.

Эрүүгийн хууль тогтвортой удаан хугацаанд мөрдөгдөж байх явдал чухал боловч уг хуулийн хэрэгжилт, үр нөлөө, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт шинжилгээ хийж, хэрэв нийцэхгүй зүйл байвал түүнийг шинэчлэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь зүйтэй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн алдаа, зөрчил, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтуудыг практикт ажиллаж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч, салбарын эрдэмтэн, судлаач судалж, засаж сайжруулбал зохих асуудлын талаар³³ өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байгаа билээ.

Түүнчлэн, практикт дээрх төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг үндэслэн шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

Тохиолдол 3.

Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар шийтгэх тогтоол³⁴, Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр магадлал³⁵, Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн 299 дүгээр тогтоолтой Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийн талаар:³⁶

Т.О, Б.Х нар нь 2017 оны 12 дугаар сарын 8-ны шөнө Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрээс тоёота аллион загварын саарал өнгийн 06-83 УВХ улсын дугаартай автомашин ашиглаж хохирогч Ц.А-гийн эзэмшлийн ногооны талбайн 20 метр урттай

³³ Эрүүгийн хууль, 1.10 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйл.

³⁴ Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruanhan/18434/view> үзнэ үү.

³⁵ Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruudavah/5384/view> үзнэ үү.

³⁶ Дэлгэрэнгүйг <http://new.shuukh.mn/eruuhyanal/962/view> үзнэ үү.

төмөр тор хулгайлж нийт 90.000 төгрөгийн хохирол учруулсан бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн бөгөөд анхан шатны шүүхээс Б.Х, Т.О нарт тус бүрт нь нэг жилийн хорих ял оногдуулсан.

Давж заалдах шатны шүүхээс энэхүү хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Харин давж заалдах шатны шүүх уг хэргийг хянан хэлэлцээд “шүүгдэгч Т.О, Б.Х нарын ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж учирсан 90.000 төгрөгийн хохирлыг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодитой хохирол учирсан гэж дүгнэхээргүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцох үндэслэлгүй гэсэн прокурорын дүгнэлтийг хүлээн авахаар тогтов” гэжээ. Ийнхүү хяналтын шатны шүүхээс ЭХХШТХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна.

Дээрх тохиолдолд анхан шатны шүүхээс машин механизм нь ашиглаж хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад 90.000 төгрөгийн хохирол учруулсан Т.О, Б.Х нарын үйлдэлд нэг жилийн хорих ял оногдуулсан бөгөөд 90.000 төгрөгийн хохирол учруулж, хохирлоо нөхөн төлсөн ч эрх чөлөөгөө нэг жилийн хугацаагаар хязгаарлуулж байгаа нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд эрүүгийн хариуцлага тохирсон эсэх нь эргэлзээтэй.

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын **хатуу цээрлэл** агуулсан арга хэмжээ³⁷ гэтэл 90.000 төгрөгийн хохирол бусдад учруулж, хорих ял эдэлнэ гэдэг нь хохирол болон нийгмийн аюулын хэр хэмжээндээ тохирох эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ байдлыг хяналтын шатны шүүхээс харгалзан үзэж Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй” гэж заасныг журамлан Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Дээрхээс дүгнэвэл, практикт прокурорын хяналтын шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэж буй тохиолдолд шүүхээс илүү байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дагаж мөрдөгдөх болсон үеэс хойш буюу 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргээр

³⁷ УДШ, Ханнс Зайделийн сан, “Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар”, 2010, 162-163 дахь тал.

шийдвэрлэгдсэн хэргүүдээс 140 хэргийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан болно.

Хүснэгт 4. Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан хэргийн тоо /Зүйл, заалтаар/³⁸

№	Зүйл, заалт	Сонгон судалсан хэргийн тоо
1	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	70
2	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт	65
3	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт	-
4	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт	1
5	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт	3
6	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3.1 дэх заалт	1
7	Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 3.2 дахь заалт	-
Нийт		140

Сонгон судалсан дээрх хэргүүдээс нийт 9 хүнд холбогдох давхар зүйлчлэлтэй 8 хавтаст хэрэг судалсан болно. Ийнхүү давхар зүйлчлэгдсэн зүйл ангиудыг судлан үзвэл:

Хүснэгт 5. Давхар зүйлчлэл /Зүйл, анги/

№	Зүйл, заалт	Давхар зүйлчлэгдсэн зүйл, анги
1	Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	2
2	Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	1
3	Эрүүгийн хуулийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	1
4	Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
5	Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
6	Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
7	Эрүүгийн хуулийн 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	1
8	Эрүүгийн хуулийн 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг Эрүүгийн хуулийн 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг	1
Нийт		8

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хавтаст хэргээс 8 хэрэг буюу 5.7 хувь нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан өөр гэмт хэргээр давхар зүйлчлэгдэн шийдвэрлэгдсэн байна. Гэхдээ энэхүү судалгаагаар санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан дээрх хэргүүдийн зөвхөн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирол, тухайн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн байдал, хулгайлах гэмт хэрэгт оногдуулсан ял зэрэг бусад асуудлыг урьдчилан бэлтгэсэн асуумжийн хүрээнд судлан үзсэн. Иймд давхар зүйлчлэлтэй бусад гэмт хэргийн улмаас

³⁸ Хавсралт 5.

хохирогчид учирсан хохирол болон бусад асуудлыг энэхүү асуумжийн хүрээнд судлан үзээгүй болно.

Өөрөөр хэлбэл, энэхүү судалгаагаар зөвхөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн улмаас учирсан хохирлын талаарх асуудлыг судалсан болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт нийт 158 хүн холбогдож, энэхүү гэмт хэргийн улмаас нийт 174 хүн хохирсон байна. Гэмт хэрэгт холбогдсон холбогдогчдын тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 6. Гэмт хэрэг үйлдсэн хүний тоо

№	Гэмт хэрэгт холбогдсон хүний тоо	Сонгон судалсан хэргийн тоо
1	Нэг холбогдогчтой	126
2	Хоёр холбогдогчтой	11
3	Гурван холбогдогчтой	2
4	Дөрвөн холбогдогчтой	1
	Нийт	140

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэргээс хулгайлах гэмт хэргийг бүлэглэн үйлдсэн 14 хэрэг байна. Энэхүү 14 хэрэгт нийт 32 хүн ял шийтгүүлсэн бөгөөд сонгон судалсан нийт хэргийн 10 хувийг хоёр буюу түүнээс дээш хүн бүлэглэн үйлдсэн тохиолдол эзэлж байна.

Бүлэглэн үйлдсэн 32 холбогдогч нь санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлсэн 158 хүний 20.3 хувийг эзэлж байна.


Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргээр шүүхээр шийдвэрлэгдсэн нийт хэргүүдээс санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт нийт 158 хүн ял шийтгүүлж, энэ гэмт хэргийн улмаас нийт 174 хүнд 331.557.991 /гурван зуун гучин нэг сая таван зуун тавин долоон мянга есөн зуун ерэн нэг/ төгрөгийн хохирол учирсан байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүний ерөнхий мэдээлэл

Санамсаргүй түүврийн аргаар дээрх 140 хэргийг сонгон судлахдаа энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн өсвөр насны яллагдагч буюу гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүнд ял оногдуулсан шийтгэх тогтоолыг сонгон судлаагүй болно. Учир нь өсвөр насны хүн нь ажил хөдөлмөр бие даан эрхлэх боломж хязгаарлагдмал, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо дан ганц өөрийн хөрөнгө мөнгө, орлогоороо төлөх боломж хомс, өөрөөр хэлбэл, өсвөр насны хүний үйлдсэн гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг ар гэрийнхэн нь ихэвчлэн төлдөг байдлыг харгалзан үзэж, санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан энэ

төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн өсвөр насны яллагдагчтай хэргийг сонгон судлаагүй болно.

График 1. Гэмт хэрэг үйлдсэн хүний насны ангилал



Хулгайлах гэмт хэргийг:

- 18-24 насны 39 буюу 24.7 хувь
- 25-29 насны 40 буюу 25.3 хувь
- 30-34 насны 29 буюу 18.4 хувь
- 35-39 насны 17 буюу 10.8 хувь
- 40-44 насны 16 буюу 10.1 хувь
- 45-49 насны 7 буюу 4.4 хувь
- 50-54 насны 7 буюу 4.4 хувь
- 55-59 насны 2 буюу 1.3 хувь
- 60-64 насны 1 буюу 0.6 хувийг тус тус эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, энэ төрлийн гэмт хэргийг 18-29 насныхан түгээмэл үйлдэж байна. Мөн санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт холбогдон ял шийтгүүлсэн хүмүүсийн дундаж дундаж нас 31.2 байна.


График 2. Өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан эсэх



Хулгайлах гэмт хэрэг үйлдсэн 158 хүнээс:

- өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан хүн 57 буюу 36.1 хувийг,
- өмнө нь гэмт хэрэг үйлдэж байгаагүй хүн 101 буюу 63.9 хувийг тус тус эзэлж байна.


График 3. Өмнө нь хулгайлах гэмт хэрэг үйлдэж байсан эсэх



Өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан 57 хүнээс хулгайлах гэмт хэрэг өмнө үйлдэж байсан 48 буюу 84.2 хувь, энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж байгаагүй 9 хүн буюу 15.8 хувийг тус тус эзэлж байна.

Дээрхээс дүгнэвэл, өмнө нь хулгайлах гэмт хэрэг үйлдэж байсан хүмүүс энэ төрлийн гэмт хэргийг дахин үйлдэх магадлал өндөр байгааг харуулж байна.


График 4. Учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрсөн эсэх



Ийнхүү гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо хүлээн зөвшөөрсөн эсэхийг судлан үзэхэд:

- Хүлээн зөвшөөрсөн 153 буюу 96.8 хувь,
- Хэсэгчлэн хүлээн зөвшөөрсөн 2 буюу 1.3 хувь,
- Хүлээн зөвшөөрөөгүй 3 буюу 1.9 хувийг тус тус эзэлж байна.
-

График 5. Хохирол төлсөн байдал




Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид төлсөн байдлыг судлан үзвэл:

- Хулгайд алдсан эд зүйлийг хүлээлгэн өгсөн 87 буюу 55.1 хувь;
- Хохирлоо бүрэн төлсөн /гомдол, саналгүй/ 40 буюу 25.3 хувь;
- Хохирлоо хэсэгчлэн төлсөн 10 буюу 6.3 хувь;
- Хохирол төлөхөө илэрхийлсэн 2 буюу 1.3 хувь;
- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлсөн ч хохирогч гомдолтой гэх 1 буюу 0.6 хувь;

- Хулгайд алдсан эд зүйлийг буцаан өгч, гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг төлсөн 6 буюу 3.8 хувь;
- Хохирол, хор уршгийг хоёуланг нь төлсөн 4 буюу 3.8 хувь;
- Хохирол огт төлөөгүй 8 хүн буюу нийт гэмт хэрэг үйлдсэн хүний 5.1 хувийг тус тус эзэлж байна.

График 6. Эрүүгийн хариуцлага оногдуулсан байдал



№	Оногдуулсан ял	Ял шийтгүүлсэн хүний тоо						Хохирол, хор уршгийг хоёуланг нь төлсөн	Хохирол төлөөгүй
		Хулгайд алдагдсан эд зүйлийн буцааж өгсөн тохиолдолд оногдуулсан ял	Хохирлоо бүрэн төлсөн /гомдол, саналгүй/	Хохирлоо хэсэгчлэн төлсөн	Хохирол төлөхөө илэрхийлсэн	Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг төлсөн ч хохирогч гомдолтой	Хулгайд алдсан эд зүйлийг буцаан өгч, гэмт хэргийн улмаас учирсан хор уршгийг төлсөн		
1	Хорих ял	10	3	7	-	-	2	-	5
2	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг журамлан хорих ял оногдуулсан	38	11	-	-	1	4	2	-
3	Нийтэд тустай ажил хийлгэх ял	24	10	2	-	-	-	1	3
4	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд зааснаар Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн	10	13	1	1	-	-	1	-
5	Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад	5	3	-	1	-	-	-	-

зааснаар хорих ял оногдуулж тэнссэн									
Нийт	87	40	10	2	1	6	4	8	
Бүгд: 158									

Хүснэгт 7.

Түүнчлэн, хулгайлах гэмт хэрэгт холбогдсон 158 хүнд шүүхээс дараах төрлийн ялыг /эрүүгийн хариуцлага/ оногдуулсан байна.

- Хорих ял 27 буюу 17.1 хувь,
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтыг журамлан хорих ял оногдуулсан 56 буюу 35.4 хувь,
- Нийтэд тустай ажил хийлгэх ял 40 буюу 25.3 хувь,
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлд зааснаар Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн 16.5 хувь,
- Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтад зааснаар хорих ял оногдуулж 9 буюу 5.6 хувийг тэнсэж, дээр дурдсан байдлаар гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулсан байна.

Дээрхээс үзвэл, хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэсэн /Хорих ял болон Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт заасан “...ялын дээд хэмжээний хоёрны нэгээс хэтрүүлэхгүй ялын доод хэмжээний хоёрны нэгээс багагүй ял оногдуулах” журамлан хорих ял оногдуулсан/ 83 хүн байна.

Өөрөөр хэлбэл, энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрлөөс хамгийн их хэрэглэгдэж буй нь хорих ял байгаа юм.


Хорих ял шийтгүүлсэн 83 хүнээс хамгийн ихдээ 60 сар буюу 5 жил бага нь 6 сар байна. Үүнээс 81 хүнийг нээлттэй, 2 хүнийг хаалттай хорих ангид ял эдлүүлэхээр тогтоосон байна. Дунджаар 17.2 сарын хорих ял оногдуулсан байна.

Нийтэд тустай ажил хийлгэх ял авсан 40 хүнээс хамгийн их нь 720 цаг, хамгийн бага нь 240 цаг. Дунджаар 327.8 цагийн нийтэд тустай ажил хийлгэх ял оногдуулсан байна.

Шүүхээс 26 хүний үйлдсэн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн бөгөөд ийнхүү тэнссэн хамгийн бага хугацаа 6 сар байгаа бол хамгийн их нь 24 сар байна. Дунджаар 12.6 сарын хугацаагаар хорих ял оногдуулахгүйгээр тэнсэх хугацаа тогтоосон байна.

Харин Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг журамлан гэмт хэрэг үйлдсэн 9 хүнд оногдуулах хорих ялыг тэнссэн байна. Ийнхүү тэнссэн хамгийн бага хугацаа нь 6 сар байгаа бол хамгийн их нь 24 сар байна. Дунджаар 12.1 сарын хугацаагаар оногдуулсан хорих ялыг тэнссэн байна.

График 7. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээ



Дээрх гэмт хэргийн улмаас нийт 174 хүнд 331.557.991 /гурван зуун гучин нэг сая таван зуун тавин долоон мянга есөн зуун ерэн нэг/ төгрөгийн хохирол учирсан бөгөөд дунджаар нэг гэмт хэргийн улмаас 2,368,271 төгрөгийн хохирол учирсан байна. Хамгийн ихдээ тухайн хавтаст хэрэгт цугларсан нотлох баримтаар 73.674.988 хохирол учирсан гэж үзсэн бол хамгийн бага нь 50,000 төгрөгийн хохирлыг тухайн гэмт хэргийн улмаас хохирогчид учруулсан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын хэмжээг судлан үзвэл:

- 50,000-300,000 төгрөгийн хохирол учирсан 23 хэрэг буюу 16.5 хувь
- 300,001-500,000 төгрөгийн хохирол учирсан 41 хэрэг буюу 29.3 хувь
- 500,001-1,000,000 төгрөгийн хохирол учирсан 31 хэрэг буюу 22.1 хувь
- 1,000,001-5,000,000 төгрөгийн хохирол учирсан 34 хэрэг буюу 24.2 хувь
- 5,000,001-10,000,000 төгрөгийн хохирол учирсан 3 хэрэг буюу 2.2 хувь
- 10,000,001-20,000,000 төгрөгийн хохирол учирсан 5 хэрэг буюу 3.6 хувь
- 20,000,001-50,000,000 төгрөгийн хохирол учирсан 2 хэрэг буюу 1.4 хувь
- 50,000,001-ээс дээш төгрөгийн хохирол учирсан 1 хэрэг буюу 0.7 хувийг тус тус эзэлж байна.

График 8. Шүүхээс хохирол төлсөн эсэхийг үнэлсэн байдал



Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт холбогдсон 158 хүний хохирогчдод учруулсан хохирлыг төлсөн эсэхийг шүүхээс үнэлсэн байдлыг судлан үзэхэд:

- Хулгайд алдсан эд зүйлийг хүлээлгэн өгсөн учир бусдад төлөх төлбөргүй гэж дурдсан 96 буюу 60.8 хувь;
- Хохирлоо төлсөн учир бусдад төлөх төлбөргүй гэж үзсэн 42 буюу 26.6 хувь;
- Хохирол төлөхөө илэрхийлсэн гэж үзсэн 5 буюу 3.2 хувь;
- 15 буюу 9.5 хувийг гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хохирогчид буцаан төлөөгүй гэж тус тус үзэж шүүх дээрх хэргүүдийг шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн улмаас хохирогчид хор уршиг учирсан эсэх, учирсан тохиолдолд шүүх тухайн хор уршигийг талаар дурдсан эсэх, хэрхэн шийдвэрлэсэн байдлыг судлан үзэхэд:

График 9. Хор уршигийг шийдвэрлэсэн байдал



- Иргэний журмаар нэхэмжлэх эрхтэйг дурдсан 1 буюу 0.6 хувь,
- Шийтгэх тогтоолоор шийдвэрлэсэн 1 буюу 0.6 хувь,
- Энэ талаар огт дурдаагүй 27 буюу 17.1 хувь,
- Хор уршиг учраагүй 123 буюу 77.9 хувь,
- Учирсан хор уршигийг арилгасан 6 буюу 3.8 хувийг эзэлж байна.

Судалгааны явцад ижил төрлийн эд зүйл хулгайд алдсан тухайн эд зүйлийг үнэлж буй үнэлгээний комиссын үнэлгээ өөр хоорондоо нэлээд зөрүүтэй байгаа нь ажиглагдсан болно. Тухайлбал, J7 утасны үнэлгээ хийсэн байдлыг харьцуулан үзвэл:

Хүснэгт 8.

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	520	2017	450.000₮
2	521	2017	544.000₮
3	703	2018	336.000₮
4	566	2018	496.000₮

5	42	2018	785.550₮
---	----	------	----------

Дээрхээс харвал, хулгайд алдагдсан J7 гар утсыг өөр хооронд нь маш их зөрүүтэй байдлаар үнэлсэн байна.

Гэтэл хохирогч нарын хувьд хулгайлах гэмт хэргийн улмаас ижил загварын, ижил үнэтэй утсыг алдахад өөр хооронд нь хэт ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь эд хөрөнгийн үнэлгээ үнэн бодитой хийгдэж буй эсэхэд эргэлзээ төрөхүйц байдлыг бий болгоод байгаа юм. Дээрх хүснэгтээс харвал, 2018 онд алдагдсан J7 гар утсыг 336.000₮, 785.550₮ гэх мэт хоорондоо маш их зөрүүтэй байдлаар үнэлсэн нь ийнхүү эргэлзээ үүсгэхэд хүргээд байна.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 140 хэрэгт ижил загварын гар утсыг хэрхэн үнэлсэн талаар товч байдлаар харуулбал:

Хүснэгт 9. Samsung S5

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	166	2018	200.000₮
2	131	2018	305.000₮
3	607	2018	300.000₮

Хүснэгт 10. Samsung S6

№	Шийтгэх тогтоолын дугаар	Шийдвэрлэгдсэн он	Эд хөрөнгийн үнэлгээ
1	166	2018	240.000₮
2	54	2018	320.000₮

Мөн хулгайлах гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхдээ:

Хэтэвчтэй мөнгө, бичиг баримт хулгайлсан тохиолдолд:

1. Зөвхөн алдагдсан бэлэн мөнгийг үнэлсэн
2. Хэтэвч, бэлэн мөнгө, виза карт, иргэний үнэмлэх зэрэг хэтэвчин дотор байсан эд зүйлийг нэг бүрчлэн үнэлсэн гэх мэт ялгамжтай байдлаар эд зүйлийн үнэлгээ хийж байна.

Тохиолдол 4.

Хэргийн товч утга: 2017 оны 7 дугаар сарын 16-ны өдөр ...улсын дугаартай автомашинаар хүргүүлэхдээ автомашины урд хайрцагнаас түрийвч, бичиг баримт, бэлэн 320.000 төгрөг хулгайлж, хохирогч "Б"-д 381.000 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт:³⁹

Дараах эд зүйлийг үнэлсэн байна.

- Бэлэн мөнгө 320.000₮
- Хэтэвч 10.000₮
- Даавуун жижиг цүнх 5.000₮

³⁹ Шийтгэх тогтоолын дугаар 318.

- Иргэний үнэмлэх 40.000₮
 - Хаан банкны виза карт 3.000₮
- Худалдаа хөгжлийн банкны карт 3.000₮

Тохиолдол 5.

Хэргийн товч утга: 2017 оны 2 дугаар сарын 21-ний өдөр Сонгинохайрхан дүүргийн 29 дүгээр хороо “ЗТВ” шүдний эмнэлэгт үйлчлүүлж байсан иргэн “Д”-гийн халааснаас түрүүвчтэй бичиг баримт, бэлэн мөнгө болон виза картнаас мөнгө авсан гэх хэрэгт:⁴⁰

Алдсан бэлэн мөнгө болон виза картнаас авсан мөнгийг хохиролд тооцож, үнэлсэн. Бичиг баримт, виза карт зэргийг үнэлээгүй байна.

Дээрх хоёр тохиолдолд хулгайлах гэмт хэргийн улмаас хохирогчид иргэний үнэмлэх, виза карт зэрэг ижил төрлийн эд зүйлсийн алдсан боловч эд зүйлийн үнэлгээ хийхдээ ялгамжтай байдлаар буюу эхний тохиолдолд иргэний үнэмлэх, банкны виза карт, хэтэвч зэргийг нэг бүрчлэн үнэлсэн байгаа бол хоёр дахь тохиолдолд эдгээр эд зүйлийг үнэлээгүй байна. Дээрхээс дүгнэвэл, практикт хулгайд алдагдсан эд зүйлийг тогтоох, үнэлэхдээ ялгамжтай байдлаар хандаж, нэгдсэн нэг ойлголтод хүрээгүй болохыг илэрхийлж байна.

Тохиолдол 6.

Хэргийн товч утга: “Б”-ийн эзэмшлийн хүн байнга амьдрах зориулалт бүхий орон байр болох байшинд хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар нэвтэрч эмэгтэй хүний мөнгөн бүс хулгайлсан гэх хэрэгт:⁴¹

- Эмэгтэй мөнгөн бүс – 210.000₮
- Цоож, цүү – 8.000 төгрөгөөр тус тус үнэлсэн байна.

Практикт орон байранд хууль бусаар нэвтрэн орж буюу хаалга, цоож эвдэх, цонх хагалах эсхүл автомашины цонхыг хагалах гэх мэтээр хулгайлах гэмт хэргийг үйлдэхдээ бусдад гэм хор учруулсан тохиолдолд тухайн эвдсэн, гэмтээсэн эд зүйлийг дийлэнх тохиолдолд үнэлэхгүй байгаа бол зарим тохиолдолд тухайлбал, дээр дурдсан “Тохиолдол 3”-т цоож, цүүг хохиролд тооцон үнэлсэн байна.

Судалгааны явцад энэ төрлийн гэмт хэргийн улмаас хаалга, цоож эвдэх, цонх хагалах гэх мэт үйлдлүүдийн улмаас хохирогчид учирсан гэм хорыг зарим тохиолдолд хохирол хэмээн үзэж үнэлэн гэмт хэрэг үйлдсэн хүнээр төлүүлж байхад ихэнх тохиолдолд огт үнэлэлгүй, энэ талаар дурдахгүйгээр хэргийг шийдвэрлэж буй дүр зураг ажиглагдаж байна.

Мөн хаалга, цоож эвдэх, цонх хагалсан тохиолдолд тухайн хаалга, цоож эвдсэн, цонх хагалсан зардлыг нотлох баримтаа бүрдүүлэн иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдаж шийдвэрлэсэн тохиолдол байна.

⁴⁰ Шийтгэх тогтоол, Дугаар 447, 2017.10.13

⁴¹ Шийтгэх тогтоол, Дугаар 217, 2018.08.23,

Тохиолдол 7.

Хэргийн товч утга: 2017 оны 7 дугаар сарын 12-ны өдөр иргэн “О”-ийн гэрт нэвтэрч 2 ширхэг хөөрөг, даалин, хавтага, бэлэн 4.000 төгрөг хулгайлсан гэх хэрэгт:⁴²

Хохирогч “О” мэдүүлэхдээ: “...Хаалганы цоож эвдсэн 100.000 төгрөг нэхэмжилж байна” гэх мэдүүлэг.

Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “...хохирогч нь хаалганы цоож эвдсэн зардал 100.000 төгрөгийг нотлох баримтаа бүрдүүлэн иргэний журмаар жич нэхэмжлэх эрхтэйг дурдсугай” гэжээ.

Энэ мэтчилэн практикт гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг үнэлэхдээ өөр хоорондоо нэлээд ялгамжтай байдлаар үнэлж байгаа нь судалгааны явцад ажиглагдсан болно. Түүнчлэн, тус гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хэт ялгамжтай /зарим тохиолдолд гэмт хэргийн улмаас учирсан хохиролд хор уршгийг оруулан үнэлсэн, зах зээлийн үнэлгээнээс хэт өндөр эсхүл хэт доогуур гэх мэт/ өөр өөр байдлаар үнэлж байгаа нь гэмт хэргийн бүрэлдэхүүн ялангуяа материаллаг бүрэлдэхүүнтэй хэргүүдийн хувьд чухал нөлөө үзүүлж байна.

Иймд практикт үүсээд буй Эрүүгийн хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудлуудад дан ганц хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бус ЭХХШТХ-д заасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа нэг мөр, ижил түвшинд явуулах нь чухал асуудал болоод байна.

Нөгөөтээгүүр, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг нь өөр материаллаг бүрэлдэхүүнтэй буюу хохирлын хэмжээ 300.000 төгрөгөөс дээш байхыг шаардаж байна. Гэтэл тус зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд хохирлын хэмжээ шаардахгүй буюу тус гэмт хэрэг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэгдсэн тохиолдолд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг болон хувирч байгаа юм.

Үүнийг нягтлах зорилгоор Монгол Улсын шүүхийн шийдвэрийн shuukh.mn цахим сангаас 2022 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн байдлаар байршуулсан хэргүүдээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан заалтуудаас практикт түгээмэл үйлдэгддэг тус зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэгдэж, тус санд байршуулсан нийт 2165⁴³ хэргээс санамсаргүй түүврийн аргаар 500 хэрэг сонгон судалж, түүнээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж шүүхээс шийдвэрлэгдсэн хэргийг түүвэрлэн судалсан болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 500 хэргээс 93 хүнд холбогдох 87 хэрэг⁴⁴ нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан 0

⁴² 2017.10.19, Шийтгэх тогтоолын дугаар 322.

⁴³ shuukh.mn (Сүүлд үзсэн огноо 2022.02.24.)

⁴⁴ Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү.

хүрээнд авч үзвэл Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн хүндрүүлэх шинж болох "орон байранд нэвтэрсэн" хулгайлах үйлдэлд хохирол шаардахгүй атлаа, "нэвтрээгүй" үйлдэлд 300.000 төгрөгнөөс дээш хохирол шаардаж байгаа нь учир дутагдалтай юм.⁴⁵

Практикт маргаан үүсгээд буй асуудлыг ерөнхийлөн авч үзвэл Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн бичвэрийг хуульчилсан явдал юм.

Тайлбарын энэхүү хэсгийг судлаач Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ" нийтлэлдээ "Монгол Улсын Үндсэн хуулийн "хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх" эрхэм зорилго, мөн тус хуулиар хамгаалсан үнэт зүйлс, шударга ёс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын "хүнтэй ... хүнлэг бусаар харьцах буюу шийтгэхийг хориглосон" 7 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн⁴⁶ хэмээн дүгнэсэн байна.

Нөгөөтээгүүр, энэхүү тайлбарыг утгачилан ойлговол Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн "энэ гэмт хэргийг..." гэдэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинж бүрэн хангагдсан тухайн гэмт хэргийг л ойлгодог. Тийм ч учраас гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний дараа харин хүндрүүлэх бүрэлдэхүүний өмнө нь "энэ гэмт хэргийг..." гэж Эрүүгийн хуулийн тухайн зүйлийн 2, 3 дахь (хэдэн хэсэгтэй ч байж болно) хэсэг болгон тусгайлан хуульчлан заадаг ба тус хэсгийн заалт болгож тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нарийвчилсан, дэс дараалсан байдлаар зохицуулдаг.⁴⁷

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийн "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үүсгэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 2-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь хорих ял эдлэх хүний тоог нэмэгдүүлэхээр байна гэж үзэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон

⁴⁵ Б.Өнөрмаа, Г.Оюунболд, "Эрүүгийн хуулийн хэрэгжилт" нийтлэл, 2017, <http://www.prokuror.mn/a/1946> (Сүүлд үзсэн: 2019.2.21)

⁴⁶ Г.Ганбаатар, Эрүүгийн хууль, 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018, №2, 80 дахь тал.

⁴⁷ Мөн тэнд.

маргаан дагуулж буй заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг⁴⁸, судалгаанууд хийгдсээр байгаа билээ. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарын хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараахь дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хамгийн түгээмэл байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан “... хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрсэн”, мөн зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан “учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн” хэргүүдэд хохирлын хэмжээ нь 300.000 төгрөг хүрээгүй хэргүүд байсан боловч шүүхээс эдгээр хэрэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу хорих ял оногдуулан шийдвэрлэж байна.

Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэж бусдад 1-300.000 төгрөгийн хохирол учруулсан үйлдэлдээ гэмт хэрэг үйлдсэн хүн 2-12 жилийн хорих ял шийтгүүлэхээр хуульчилжээ.

Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахын зэрэгцээ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан “Шударга ёсны зарчим”-тай зөрчилдөж байна хэмээн дүгнэж болох юм.

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт дан ганц хорих ял оногдуулахаар хуульчилсан нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, учруулсан хохирол зэрэг олон шалтгаан нөхцөлийг шүүх тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн хүнд тохирох ял шийтгэлийг оногдуулахад хязгаарлагдмал байдлыг бий болгож байна хэмээн үзэж болох юм.

Энэхүү судалгааны явцад шүүгч, прокуроруудаас анкетын аргаар судалгаа авахад энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах боломжтой гэж нийт оролцогчдын 39.8 хувь нь хариулсан нь энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж хуульчлах боломжийг судлан үзэх шаардлагатай болохыг илэрхийлж байна.

⁴⁸ УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ, “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг”, “Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг, “Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц” сэдэвт хэлэлцүүлэг, “Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа - онол практикийн асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал гэх мэт.

4.2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргаж байна. Үүний тулд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгээс “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн хэсгийг хасах;

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялын төрлийг нэмэх. Тухайлбал, арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялыг нэмэх.⁴⁹

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2017, №23;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, 1987 он;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль (1971 оны 03-р сарыг дуустал гарсан нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулав), 1971 он;
- БНМАУ-ын Эрүүгийн хууль, ШЯЯ, 1949 он;

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Д.Лүндээжанцан, Хууль бүтээх үйл ажиллагаа ба хууль зүйн техник, 2016 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСАЗЗ, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСАЗЗ, 2018 он

⁴⁹ Практикт түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн нэг болох Эрүүгийн хууль, 17.3 дугаар зүйлд заасан “Залилах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд энэ хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “...арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасныг харгалзан үзэж дээрх саналыг гаргасан болно.

- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;
- Монгол Улсын Эрүүгийн Хууль, Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх Хууль (Монгол Улсын Эрүү, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн тайлбарууд), ХЗЯ, 1995 он;
- Парламентын судалгааны эмхэтгэл 21 боть. УИХТГ, Парламентын судалгааны хүрээлэн
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Т.Кашанина, Хууль зүйн техник, 2016 он;
- Үндсэн хуулийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2011 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrence theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” нийтлэл, 2017 он.

Цахим эх сурвалж

- Basic Law of the Federal Republic of Germany. Available at. <https://www.bundestag.de>
- Judcouncil.mn, [Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас](http://Judcouncil.mn).
- Legalinfo.mn, [Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем](http://Legalinfo.mn);
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Конституция рф. Глава 7.статья 126. Available at. <https://constitutionrf.ru/rzd-1/gl-7/st-126-krf>

Хавсралт 1. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль дахь аутентик тайлбар бүхий зүйл, заалтууд

№	Зүйл, заалт	Аутентик тайлбар
Ерөнхий анги		
1	2.5 дугаар зүйл.Гэмт хэргийн хохирол, хор уршиг	Тайлбар: -Энэ хуульд заасан "нэгж" гэж энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг ойлгоно.
2	4.1 дүгээр зүйл.Аргагүй хамгаалалт	Тайлбар: -Энэ хуульд заасан "ойр дотны хүн" гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно. <u>/Энэ зүйлийн тайлбарыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон./</u>
3	4.2 дугаар зүйл.Баривчлах, таслан зогсоох зорилгоор халдах	Тайлбар: -Энэ хуульд заасан "хууль сахиулагч" гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагч, хуулиар тусгайлан эрх олгосон эрх бүхий этгээд, байгаль хамгаалагчийг ойлгоно.
4	6.6 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал	Тайлбар: -Энэ хуульд заасан "ойр дотны хүн" гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно. <u>/Энэ зүйлийн тайлбарыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./</u>
Тусгай анги		
5	10.1 дүгээр зүйл.Хүнийг алах	Тайлбар: -Энэ хуульд заасан "бага насны хүүхэд" гэж арван дөрвөн насанд хүрээгүй хүнийг ойлгоно.
6	10.4 дүгээр зүйл.Хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх	Тайлбар: -Энэ хуульд заасан "гэр бүлийн хамаарал бүхий харилцаа" гэж гэр бүлийн гишүүд, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаа, гэрлэлт нь цуцлагдсан, бусад шалтгаанаар хамт амьдарч байгаад больсон хүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асрамжийн үйлчилгээ үзүүлж байгаа хүн, тэдгээрийн асрамжид байгаа хүмүүсийн хоорондын харилцааг ойлгоно.
7	10.5 дугаар зүйл.Эх нярай хүүхдээ алах	Тайлбар: -Энэ хуульд заасан "нярай хүүхэд" гэж төрснөөсөө хойш гурав хоногоос хэтрээгүй байсныг ойлгоно.

8	11.1 дүгээр зүйл.Хүний эрүүл мэндэд хүнд хохирол санаатай учруулах	Тайлбар: -Энэ хуульд заасан "зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл" гэж иж бүрдэл, бүтцийн хувьд аливаа биетийг устгах, гэмтээх, бие хамгаалах, дохио өгөх зориулалттай эд зүйл, тоног төхөөрөмж, хэрэгслийг хамааруулж ойлгоно. Зэвсэг нь галт, хүйтэн, хийн, үйлдвэрийн, гар хийцийн аль нь ч байж болно. "Тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл" гэж хүний биед гэмтэл, эд хөрөнгөд хохирол учруулахаар тусгайлан бэлтгэсэн, засаж тохируулсан хүйтэн зэвсэг, галт зэвсэг, эд зүйл, хэрэгслийг ойлгоно.
9	12.1 дүгээр зүйл.Хүчиндэх	Тайлбар: -Хүчиндэх гэмт хэргийн хохирогч нь бэлгийн халдашгүй байдал нь зөрчигдсэн аль ч хүйсийн хүн байж болно. -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. -"Бэлгийн харьцааны шинжтэй хүч хэрэглэсэн үйлдэл" гэж хохирогчийн биеийн аль нэг хэсэгт бэлэг эрхтнээ оруулсан; хохирогчийн бэлэг эрхтэнд өөрийн бусад эрхтэн, эсхүл өөр зүйл оруулсныг ойлгоно.
10	12.2 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах	Тайлбар: -Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно.
11	12.3 дугаар зүйл.Бэлгийн мөлжлөг	Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.
12	12.6 дугаар зүйл.Биеэ үнэлэхийг зохион байгуулах	Тайлбар: -Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.
13	13.1 дүгээр зүйл.Хүн худалдаалах	Тайлбар: -Хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй. -Энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход хохирогч өөрийг нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар хохироож байгааг өөрөө зөвшөөрсөн эсэх нь гэмт хэргийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.
14	13.2 дугаар зүйл.Хүн хулгайлах	Тайлбар: -Бага насны хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцоход энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар үйлдсэн байхыг шаардахгүй.
15	13.3 дугаар зүйл.Хүн барьцаалах	Тайлбар: -Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан хүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг ялаас чөлөөлнө.

16	13.6 дугаар зүйл.Бусдын орон байранд хууль бусаар нэвтрэн орох	Тайлбар: -Энэ хуульд заасан "орон байр" гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.
17	13.8 дугаар зүйл.Зөвшөөрөлгүй гэрэл зураг авах, дуу, дүрс бичлэг хийж дамжуулах, тараах	Тайлбар: -Энэ бүлэгт заасан "эрх бүхий албан тушаалтан" гэж хуульд заасны дагуу мөрдөн шалгах, хэрэг бүртгэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий хүнийг ойлгоно.
18	17.1 дүгээр зүйл.Хулгайлах	Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.
19	17.4 дүгээр зүйл.Хөрөнгө завших	Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.
20	17.12 дугаар зүйл.Мал хулгайлах	Тайлбар: -Энэ зүйлд заасан "мал" гэдэгт хонь, ямаа, адуу, үхэр, тэмээ хамаарна. -Энэ зүйлд заасан "олон тооны мал" гэж найман бог, хоёр бод, түүнээс дээш малыг ойлгоно. Богийг бодод шилжүүлэхдээ нэг бодыг дөрвөн богоор тооцно.
21	18.5 дугаар зүйл.Улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх	Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн барааг хяналт шалгалтын үеэр, эсхүл мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.

22	18.20 дугаар зүйл.Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаанд арилжааг урвуулан ашиглах	<p>Тайлбар:-Энэ зүйлд заасан “хуурамч арилжаа хийсэн” гэж виртуал хөрөнгийн арилжаанд оролцогч, харилцагчийг төөрөгдүүлэхийн тулд тодорхой виртуал хөрөнгийн өмчлөгч нь өөрчлөгдөөгүй боловч арилжаа идэвхтэй явагдаж байгаа дүр үзүүлэн хэлцэл хийх болон үгсэн хуйвалдах замаар тодорхой виртуал хөрөнгийг худалдах, худалдан авах үнийг ойролцоо түвшинд захиалах, хэлцэл хийхийг ойлгоно.</p> <p>-Энэ зүйлд заасан “үнэ ханшийг зохиомлоор тогтоосон” гэж тодорхой виртуал хөрөнгийг бусад этгээд худалдан авах, худалдан авахгүй байх, захиалах, захиалахгүй байх нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ханшийг өсгөх, бууруулах, тодорхой түвшинд барихад чиглэсэн хоёр ба түүнээс дээш хэлцэл хийхийг ойлгоно.</p> <p>-Энэ зүйлд заасан “оролцогч, харилцагчийг арилжаанд оролцуулах, эсхүл оролцуулахгүй байх зорилгоор хууран мэхэлсэн” гэж бодит бус, төөрөгдүүлсэн, эсхүл хуурамч мэдэгдэл, амлалт, таамаг гаргах, нийтлэх, чухал үйл баримтыг нуун дарагдуулах, бодит үйл баримтын талаар худал мэдэгдэл хийх замаар болон тодорхой арга, хэрэгсэл, тоног төхөөрөмж ашиглан хэлцлийн нөгөө тал болох этгээдийг төөрөгдүүлэхийг ойлгоно.</p> <p><u>/2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн хуулиар нэмсэн./</u></p>
23	19.4 дүгээр зүйл.Гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах	Тайлбар: -Гадаад улсын тагнуулын албатай хамтран ажиллахаар тохиролцсон боловч төрийн зохих байгууллагад сайн дураараа даруй мэдэгдсэн, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэхэд туслалцаа үзүүлсэн иргэний үйлдэл нь өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө.
24	19.7 дугаар зүйл.Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэх	Тайлбар: -Хорлон сүйтгэх ажиллагаанд бэлтгэхэд оролцсон хүн гэмт хэргээ сайн дураараа илчилсэн, төрийн байгууллагад цаг тухайд нь сэрэмжлүүлсэн, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсооход бодитой тус дөхөм үзүүлсэн тухайн хүний үйлдэл өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө.
25	19.10 дугаар зүйл.Тагнуул хийх	Тайлбар: -"Тагнуул хийх" гэж гадаад улсын тагнуулын байгууллагын үүрэг даалгавар гүйцэтгэсэн, Монгол Улсын иргэнийг гадаадын тагнуулын албатай нууцаар хамтран ажиллахыг ятгасан, ажиллуулсан, төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлийг хулгайлсан, цуглуулсан, хадгалсан, дамжуулсан үйлдлийг ойлгоно

26	19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх	<p>Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэн гарсан Монгол Улсын иргэн хэргээ илчлэн ирсэн бол ялаас чөлөөлж болно.</p> <p>-Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.</p> <p>-Хүн худалдаалах, хүн хулгайлах гэмт хэргийн хохирогч болсон хүн баримт бичиггүйгээр, хуурамч баримт бичгээр Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.</p>
27	20.4 дүгээр зүйл.Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших	<p>Тайлбар: -Гэрчилгээгүй галт зэвсэг, түүний бүрдэл хэсэг, тэсэрч дэлбэрэх бодис, галт хэрэгсэл, тэсэлгээний хэрэгслийг хууль бусаар олж авсан, хадгалж байсан хүн зохих байгууллагад сайн дураараа авчирч өгсөн бол ялаас чөлөөлнө.</p>
28	20.7 дугаар зүйл.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах	<p>Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг сайн дураараа шилжүүлэн өгсөн, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсооход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээртэй адилтгах зүйлийг мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.</p>
29	21.6 дугаар зүйл.Шүүгч, прокурор, өмгөөлөгч, мөрдөгч, иргэдийн төлөөлөгчид хууль бусаар нөлөөлөх	<p>Тайлбар: -"Улс төрд нөлөө бүхий этгээд" гэж Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн даргыг ойлгоно.</p>
30	22.1 дүгээр зүйл.Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах	<p>Тайлбар: -Энэ хуульд заасан "албан тушаалын байдал" гэдэгт эрх нөлөө хамаарна.</p> <p>-Энэ хуульд заасан "урвуулан ашиглах" гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.</p> <p><u>/Энэ зүйлийн тайлбарыг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./</u></p>

31	22.3 дугаар зүйл.Гадаад улсын төрийн байгууллага, олон улсын байгууллагын албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах	Тайлбар: -Энэ хуульд заасан "олон улсын байгууллагын албан тушаалтан" гэж олон улсын, Засгийн газар хоорондын олон улсын байгууллагын ажилтан, тухайн байгууллагыг төлөөлөх, тухайн байгууллагын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий, тухайн байгууллагаас томилогдсон хүнийг ойлгоно.
32	22.5 дугаар зүйл.Хахууль өгөх	Тайлбар: -Хясан боогдуулсны улмаас аргагүй байдалд орж хахууль өгч, нийтийн албан тушаалтны хуулийн дагуу албаны чиг үүргээ гүйцэтгэж үзүүлэх төрийн үйлчилгээг авсан хүн энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчлэн ирсэн бол түүний авсан төрийн үйлчилгээг хэвээр үлдээж ялаас чөлөөлнө.
33	27.4 дүгээр зүйл.Нисэх багийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох	Тайлбар: -Энэ зүйлд заасан "нислэг" гэж агаарын хөлгийг ачаалсны дараа бүх гадна хаалгыг хаасан үеэс эхлэн хүн, ачаа буулгахаар аль нэг хаалгыг нээх хүртэл агаарын хөлгийг нислэг үйлдэж байгаад тооцно. Онцгой тохиолдлын буулт хийх тохиолдолд зохих эрх бүхий этгээд агаарын хөлөг, түүнд байгаа хүмүүс, эд хөрөнгийн төлөө хүлээх хариуцлагыг шилжүүлж авах хүртэл нислэгийг үргэлжилж байгаад тооцно.
34	28.1 дүгээр зүйл.Тушаал биелүүлэхгүй байх	Тайлбар: -"Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг" гэж Монгол Улсын зэвсэгт хүчин, хилийн цэргийн бие бүрэлдэхүүнд цэргийн жинхэнэ алба хааж байгаа Монгол Улсын иргэн, цэргийн дайчилгаа, сургууль, цугларалтад байгаа цэргийн үүрэгтэн энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдсэнийг ойлгоно.
35	29.8 дугаар зүйл.Террорист үйлдэл хийх	Тайлбар: - Энэ зүйлд заасан "объект барьцаалсан" гэж тээврийн хэрэгсэл, барилга байгууламж, хүн амын амьдралыг хангах болон олон улсын хамгаалалтад байдаг объект барьцаалсан үйлдлийг ойлгоно. <u>/Энэ зүйлийн тайлбарыг 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар нэмсэн./</u>
36	29.9 дүгээр зүйл.Террорист үйлдэлд бэлтгэх	Тайлбар: - Террорист үйлдлийг бэлтгэхэд оролцсон хүн гэмт хэргээ сайн дураар илчилсэн, төрийн байгууллагад цаг тухайд нь сэрэмжлүүлсэн, террорист үйлдлийг таслан зогсооход бодитой тус дөхөм үзүүлсэн тухайн хүний үйлдэл өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө. <u>/Энэ зүйлийн тайлбарт 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан./</u>

37	29.10 дугаар зүйл.Терроризмыг санхүүжүүлэх	<p>Тайлбар: - Энэ зүйлд заасан "хориг арга хэмжээ" гэж Нэгдсэн Үндэстний Байгууллагын Аюулгүйн зөвлөлийн тогтоолоор баталсан үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэхтэй холбоотой санхүүгийн хориг арга хэмжээ, түүнчлэн Засгийн газраас терроризмтой тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын саналыг үндэслэн баталсан жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн эсрэг санхүүгийн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг ойлгоно.</p> <p>- Энэ зүйлд заасан гэмт хэргийн талаар төрийн зохих байгууллагад сайн дураараа даруй мэдэгдсэн, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэхэд туслалцаа үзүүлсэн иргэний үйлдэл нь өөр гэмт хэргийн шинжгүй бол ялаас чөлөөлнө. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.</p>
----	--	---

Дээрхээс үзвэл, Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нийт 37 аутентик тайлбар бүхий зүйл, заалт байна.

Эрүүгийн хуулийн 1.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад Монгол Улсын хууль, Монгол Улсын хуулиар соёрхон баталсан, нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан тодорхойлолт, хэм хэмжээг баримтална...” гэж мөн зүйлийн 5 дахь хэсэгт “...Энэ хуулийн нэр томьёо, ухагдахууныг тайлбарлахад захиргааны хэм хэмжээний актыг ашиглаж болно...” гэж тус тус заажээ. Дээр дурдсан Эрүүгийн хууль дахь аутентик тайлбаруудаас, хууль тогтоомжид нэр томьёог тайлбарлан хуульчилсан байдал цөөнгүй байна. Тухайлбал, Хууль тогтоогчдын зүгээс одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 4, тусгай ангийн 33 зүйл заалтад аутентик тайлбар хийсэн байх бөгөөд эдгээр тайлбарын дийлэнх нь тухайн заалтын нэр томьёог хэрхэн ойлгож хэрэглэх, ямар үйлдлийн аргаар үйлдсэн тохиолдолд гэмт хэрэг үйлдсэнд тооцох, тооцохгүй байх зэргийг тайлбарласан байна. Нэр томьёог тайлбарлахдаа

Хавсралт 2. Өмнөх Эрүүгийн хуулиуд дахь аутентик тайлбар бүхий зүйл, заалтууд

№	Зүйл, заалт	Аутентик тайлбар
2002 оны Эрүүгийн хууль		
1	79 дүгээр зүйл. Эх орноосоо урвах	Тайлбар: Гадаад улсын тагнуулын албанд элссэн боловч авсан даалгавараа биелүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын албатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн Монгол улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
2	82 дугаар зүйл. Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах	Тайлбар: төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулахад оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө энэ тухай төрийн зохих байгууллага, албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийнм эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
3	89 дүгээ зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх	Тайлбар: Үзэл бодол, улс төрийн болон шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн орогнох эрх олж авахын тулд хууль бусаар Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ зүйл хамаарахгүй.
4	108 дугаар зүйл. Хүн хулгайлах	Тайлбар: Хүн хулгайлсан үйлдэл нь бие даасан өөр гэмт хэргийн шинжгүй бөгөөд хулгайлагдсан хүнийг сайн дураараа сулласан этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.
5	112 дугаар зүйл. Хүнийг барьцаалах	Тайлбар: Барьцаанд байгаа хүнийг сайн дураараа сулласан этгээдийн үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
6	177 дугаар зүйл. Зандалчлах	Тайлбар: Зандалчлах гэмт хэрэгт бэртгэхэд идэвхитэй оролцсон боловч гэмт үйлдэл эхлэхээс өмнө эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэдэгдсэн, эсхүл энэ үйлдлийг таслан зогсооход идэвхитэй оролцсон бөгөөд түүний үйлдэлд өөр гэмт хэргийн шинжгүй бол эрүүгийнм хариуцлагаас чөлөөлж болно.
7	185 дугаар зүйл. Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар хийж, бэлтгэх, хадгалах, авч явах, борлуулах, үйлдвэрлэх	Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодисыг зохих зөвшөөрөлгүй хадгалж байгаад зохих байгууллагад сайн дураараа авчирч өгсөн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

8	251 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын болон ашиглалтын журам зөрчих	Тайлбар: Энэ зүйлд заасан жолооч гэдэгт тээврийн хэрэгсэл жолоодож байгаа жолоодох эрхийн үнэмлэхтэй, үнэмлэхгүй аливаа этгээд, “тээврийн хэрэгсэл” гэдэгт хүн, ачаа тээвэрлэхэд зориулсан бүх төрлийн автомашин, мотоцикл, трактор, өөрөө явагч бусад машин, цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн бусад механикжсан тээврийн хэрэгслийн тус тус ойлгоно.
9	231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох	Тайлбар: Энэ хуулийн 230. 231 дүгээр зүйлд заасан Төрийн албан хаагч гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийншийдвэр гүйцэтгэгч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.
10	258 дугаар зүйл. Шүүхийн шийдвэрийг үл биелүүлэх	Тайлбар: Энэ зүйлд заасан гэмт хэрэгт сэжигтэнээр тооцогдсон, яллагдагчаар татагдсан, ял шийтгэгдсэн этгээд шүүхийн шийдвэрийг биелүүлсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
11	263 дугаар зүйл. Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн албан тушаалтан гэдэгт төрийн улс төрийн, тусгай, захиргааны болон үйлчилгээний албаны удирдах албан тушаалтныг хамааруулна.
12	265 дугаар зүйл. Төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан эрх мэдлээ урвуулах	Тайлбар: Энэ бүлэгт дурдсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтан гэдэгт төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид удирдах, гүйцэтгэх албан тушаал эрхэлж байгаа этгээдийг хамааруулна.
13	269 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх	Тайлбар: Хээль, хахууль өгсөн этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа илчилж ирсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
14	270 дугаар зүйл. Хээл хахууль зуучлах	Тайлбар: Хээл, хахууль зуучилсан этгээд энэ тухайгаа эрх бүхий байгууллагад сайн дураараа мэдэгдсэн бол эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
15	301 дүгээр зүйл. Олон улсын хамгаалалтад байдаг хүмүүст халдан довтлох	Тайлбар: Энэ зүйлд дурдсан олон улсын хамгаалалтад байдаг хүмүүс гэдэгт гадаад улсаас Монгол Улсад суугаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад улсын гадаад худалдааны байгууллагын ажилтнууд, дипломат элч, түүнчлэн гадаад улсаас Монгол Улсад албан ёсны болон ажлын айлчлалаар ирсэн гадаад улсын төрийн тэргүүн, түүний гэр бүл буюу Монгол Улсад өөрийн улсын төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулах эрх бүхий этгээд хамаарна. Дээр дурдсан хүмүүсийн орон байр, албан өрөө, тээврийн хэрэгсэл олон улсын хамгаалалтад байна.
1995 онд Монгол Улсын Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт		

1	60 дугаар зүйл. Эх орноосоо урвах	Тайлбар: Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулахаар гадаад улсын тагнуулын байгууллагад элсэгдсэн боловч авсан даалгавараа биелүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын байгууллагатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн Монгол Улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
2	79 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх	Тайлбар: Монгол Улсын үндсэн хуулийн ёсоор олгогдсон тус улсад оршин суух эрх эдлэхийн тулд гадаадын иргэд зохих паспортгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй Монгол Улсад орж ирсэн тохиолдолд энэ зүйл хамаарахгүй.
3	123 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлж, ашиглан шамшигдуулах	Тайлбар: Энэ хуулийн 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан давтан гэдэг нь урьд эдгээр зүйл буюу 73, 125, 130, 245 дугаар зүйлдт засан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэний дараа 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэнийг хэлнэ.
4	192 дугаар зүйл. Эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	Тайлбар: Энэ бүлэгт дурдсан албан тушаалтан гэдэгт засгийн төлөөлөгчийн үүргийг байнга буюу түр гүйцэтгэж байгаа түүнчлэн улс, хоршоолол, олон нийтийн үйлдвэр албан газар, байгууллагад захирамжлах-зохион байгуулах захиргаа-аж ахуйн үүргийг биелүүлэхтэй холбогдсон албан тушаал, байнга буюу түр эрхэлж байгаа, эсхүл тийм үүргийг тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу гүйцэтгэж байгаа хүмүүс хамаарна.
5	196 дугаар зүйл. Хээль хахууль өгөх	Тайлбар: Хясан боогдуулсны улмаас хээл хахууль өгсөн боловч энэ тухайгаа зохих байгууллага буюу албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
6	203 дугаар зүйл. Илт хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал гаргах	Тайлбар: Эрүүгийн хуулийн 201, 202, 203 дугаар зүйлд заасан гэмт хэргийг тухайн зүйлд зааснаас бусад сэдэлтээр үйлдвэл энэ хуулийн 194 дүгээр зүйлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.
7	247 дугаар зүйл. Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаал авч явах, хийж бэлтгэх, олж авах, хадгалах, борлуулах	Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис зохих зөвшөөрөлгүй хадгалж байгаад сайн дураар авчирч өгсөн этгээдийн эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

8	260 дугаар зүйл. Тээдрийн хэрэгсэл жолоодож байгаа этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээдрийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	Тайлбар: Энэ хуулийн 260, 261, 263, 267 дугаар зүйлд зассан тээврийн хэрэгсэл гэдэг бүх төрлийн автомашин, трактор болон өөрөө явагч бусад машин хотын цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн мотоцикл болон бусад механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.
1986 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль		
1	60 дугаар зүйл. Эх орноосоо урвах	Тайлбар: Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулахаар гадаад улсын тагнуулын байгууллагад элсэгдсэн боловч авсан даалгавараа биелүүлэх талаар ямар нэг үйлдэл хийгээгүй бөгөөд гадаадын тагнуулын байгууллагатай холбоотой болохоо төрийн зохих байгууллагад сайн дураараа мэдэгдсэн Монгол Улсын иргэнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
2	79 дүгээр зүйл. Хууль бусаар Монгол Улсын хил нэвтрэх	Тайлбар: Монгол Улсын үндсэн хуулийн ёсоор олгогдсон тус улсад оршин суух эрх эдлэхийн тулд гадаадын иргэд зохих паспортгүй буюу эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй Монгол Улсад орж ирсэн тохиолдолд энэ зүйл хамаарахгүй.
3	123 дугаар зүйл. Бусдын эд хөрөнгийг хулгайлж, ашиглан шамшигдуулах	Тайлбар: Энэ хуулийн 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан давтан гэдэг нь урьд эдгээр зүйл буюу 73, 125, 130, 245 дугаар зүйлдт засан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэний дараа 123, 124, 126, 127 дугаар зүйлд заасан гэмт хэргийн аль нэгийг үйлдсэнийг хэлнэ.
4	192 дугаар зүйл. Эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах	Тайлбар: Энэ бүлэгт дурдсан албан тушаалтан гэдэгт засгийн төлөөлөгчийн үүргийг байнга буюу түр гүйцэтгэж байгаа түүнчлэн улс, хоршоолол, олон нийтийн үйлдвэр албан газар, байгууллагад захирамжлах-зохион байгуулах захиргаа-аж ахуйн үүргийг биелүүлэхтэй холбогдсон албан тушаал, байнга буюу түр эрхэлж байгаа, эсхүл тийм үүргийг тусгайлан олгосон бүрэн эрхийн дагуу гүйцэтгэж байгаа хүмүүс хамаарна.
5	196 дугаар зүйл. Хээль хахууль өгөх	Тайлбар: Хясан боогдуулсны улмаас хээл хахууль өгсөн боловч энэ тухайгаа зохих байгууллага буюу албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
6	203 дугаар зүйл. Илт хууль бус таслан шийдвэрлэх тогтоол, шийдвэр, магадлал гаргах	Тайлбар: Эрүүгийн хуулийн 201, 202, 203 дугаар зүйлд заасан гэмт хэргийг тухайн зүйлд зааснаас бусад сэдэлтээр үйлдвэл энэ хуулийн 194 дүгээр зүйлийн дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ.

7	247 дугаар зүйл. Зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаал авч явах, хийж бэлтгэх, олж авах, хадгалах, борлуулах	Тайлбар: Галт зэвсэг, байлдааны галт хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис зохих зөвшөөрөлгүй хадгалж байгаад сайн дураар авчирч өгсөн этгээдийн эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.
8	260 дугаар зүйл. Тээврийн хэрэгсэл жолоодож байгаа этгээд хөдөлгөөний аюулгүй байдлын болон тээврийн хэрэгслийн ашиглалтын журам зөрчих	Тайлбар: Энэ хуулийн 260, 261, 263, 267 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл гэдэгт бүх төрлийн автомашин, трактор болон өөрөө явагч бусад машин хотын цахилгаан тээврийн хэрэгсэл, түүнчлэн мотоцикл болон бусад механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно.
1961 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль		
1	45 дугаар зүйл. Эх орноосоо урвах	б. Гадаадын тагнуулд элсэж, өөрийн орны эсрэг ажил явуулрага гүйцэтгэх даалгавар авсан боловч уг даалгаварыг биелүүлээгүй, засан төрийн зохих байгууллагад өөрийгөө илчлэн ирсэн БНМАУ-ын иргэнийг энэ хэрэгт нь эрүүгийн хариуцлагад татахгүй.
2	61 дүгээр зүйл. Хууль бусаар хил хязгаар нэвтрэх	Энэ зүйл БНМАУ-ын үндсэн хуульд зааснаар тус улсын оршин суух эрх олгогдох гадаадын иргэдэд хамаарагдахгүй.
3	135 дугаар зүйл. Албан тушаалын ойлголт	Улс, олон нийтийн байгууллага, үйлдвэр, аж ахуйн газруудад байнга буюу түр албан тушаал эрхэлж тэдгээр байгууллагал захирамжлах-зохион байгуулах буюу захиргаа аж ахуйн тодорхой албан үүрэг гүйцэтгэж байгаа хүмүүсийг албан тушаалтан гэж үзнэ.
4	139 дүгээр зүйл. Хээл хахууль өгөх ба хээл хахууль өгч авалцахад зуучлан дамжуулах	Хээл хахуулийг албан тушаалтны далайлган сурдүүлснээр өгсөн буюу хээл хахууль өгсөн этгээд эрүүгийн хэрэг үүсгэхээс өмнө зохих байгууллага буюу хариуцлагатанд мэдэгдвэл тэдэнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй.
4	154 дүгээр зүйл. Нутаг заагдсан этгээд оргх буюу нутаг зайлуулагдсан этгээд дур зоргоороо иргэж ирэх буюу засан	в. Засан хүмүүжүүлэх ажлаас санаатайгаар зайлсхийвэл засан хүмүүжүүлэх аулын үлдэж байгаа хугацааг хорих ялаар ч солих боловч есөн сараас хэтрүүлж болохгүй.

	хүмүүжүүлэх зайлсийх	ажлаас	
5	191 дүгээр зүйл. Цэргийн гэмт хэргийн ойлголт		Цэргийн алба хаах тухай тогтоосон журмын эсрэг, энэ хуульд заасан гэмт хэргийг цэргийн албан хаагчдаас үйлдсэн буюу мөн цэргийн алба хаах үүрэг бүхий хүн түр сургууль хийж байх үедээ үйлдвэл цэргийн гэмт хэрэг гэж үзнэ. Нийгмийг аюулаас хамгаалах байгууллагын офицер, түрүүч, байлдагч нараас өөрийнхөө алба хаах тухай тогтоосон журмын эсрэг гэмт хэрэг үйлдвэл энэ хуулийн зохих зүйлүүдэд зааснаар шийтгэнэ. Энэ зүйлд дурдаагүй хүн цэргийн гэмт хэрэгт хамааран орлоцвол цэргийн гэмт хэргийн нэгэн адил шийтгэнэ.
1942 оны БНМАУ-ын Эрүүгийн хууль			
1	79 дүгээр зүйл		Тайлбарлах нь: энэхүү зүйлд заан дурдсан шинж ялгавруудгүйгээр конторбанд үйлдэх болбол гайлын дүрмийн ёсоор торгож энэхүү хуулийн 104 дүгээр зүйлд заасныг баримтлан шийтгэнэ.
2	80 дугаар зүйл		Тайлбарлах нь: хэрэв дээр дурдсан ялгаваргүйгээр алдаагаар буюу малын тэжээл, өвс ногоо, ус эрэх зэрэг шалтгаанаас гадаад улсаас Бүгд Найрамдах Монгол Ард Улсын хилийг нэвтрэн орж ирэгчдийг мал хөрөнгөний хамт Дотоод Явдлын Яамны байгууллагаас заасан газар нутагт нэгээс таван жилийн хугацаанд албаар нүүлгэн суулгана.
3	104 дүгээр зүйл		Тайлбарлах нь: хөдөлмөрчин ард түмний эрх ашгийг хамгаалсан буюу үндэсний эрх чөлөөний төлөө тэмцэн явдалд хавчигдсаны улмаас зайлс хийж тус Бүгд Найрамдах Монгол Ард Улсад тогтоосон журмын паспорт буюу засаг захиргааны байгууллагын үнэмлэхгүйгээр нэвтрэн ирсэн гадаадын харъяат нарт улсын Үндсэн хуулийн 88 дугаар зүйлийн ёсоор өөрийн улсад оршин суух эрхийг олгох учир энэхүү зүйл үл холбогдоно.
4	123 дугаар зүйл		Тайлбарлах нь: Улсын албан ба үйлдвэрийн газруудад байнга буюу түр албан тушаалыг явуулж байгаа мөн түүнчлэн аж ахуйн ба захирах тушаах хийгээд ажил төрлийн эвлэлүүд буюу улсын бусад зорилго бодлогуудыг биелүүлэх ядвалд хууль буюу уул дагаж явахаар даалгагдсан эрх үүргийг биелүүлэх ийм олон нийтийн байгууллагад байнга буюу түр албан тушаалыг явуулж байгаа хэн нэгэн хүмүүсийг албан тушаалтан гэж үзнэ.
5	131 дүгээр зүйл		Тайлбарлах нь: хэрэв эд хахуулийг өгөх буюу авалцахад зуучлан уламжилсан нь шахагдаж өгсөн буюу эд хахуулийг өгсний даруйд эл учрыг сайн дураар мэдүүлсэн байвал ял шийтгэхийг үл хэлэлцэнэ.
6	161 дүгээр зүйл		Тайлбарлах нь: Хувьсгалын эсэргүү зорилгоор бусдыг санаатайгаар буруу эмчилбэл гэмт этгээдийг 63 дугаар зүйлийн ёсоор шийтгэнэ. Хэрэв санаатайгаар боловч хувьсгалын эсэргүү зорилгогүй харин

		өөр нэгэн шалтгаанаар тийнхүү буруу эмчилсэн байвал 148 дугаар зүйл ба 155 дугаар зүйлийн ёсоор шийтгэвэл зохино.
7	194 дүгээр зүйл	Тайлбарлах нь: Цэргийн гэмт явдлыг үйлдсэн хэрэгт энэхүү зүйлд дурдаагүй хүмүүсээс оролцсон байвал цэргийн гэмт явдлын тухай бүлгийн зүйл ангийг баримтлан шийтгэнэ.
8	198.1 дүгээр зүйл	Тайлбарлах нь: Доромжилсон ба доромжлогдсон хүмүүс нь тушаал буюу зэргийн талар бие биед үл захирагдах бөгөөд үүний аль нэгэн нь цэргийн албаны үүргийг гүйцэтгэж байсан боловч уул доромжилсон этгээд нь ялыг дээр дурдсан ёсоор хүлээнэ.
9	121 дүгээр зүйл	Тайлбар: энэхүү зүйл нь энэ хуулийн 11 дүгээр бүлгийг нийтлэн гаргахын өмнө эр, эм бололцогчдод үл хамаарна.

Хавсралт 3. Эрүүгийн хуультай холбоотой УДШ-ээс гаргасан тогтоол

№	Тогтоол гаргасан он, сар, өдөр	Улсын дээд шүүхийн тогтоолын дугаар	Тайлбар хийсэн зүйл, заалт
1	2009.06.24	Дугаар 23 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 28 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ	<p>"албаны эрх мэдэл" гэдгийг сонгуульт болон томилолтын албан тушаалтанд хууль тогтоомжоор олгосон бүрэн эрх, үндсэн чиг үүргийн нэгдэл гэж ойлгоно.</p> <p>"албан тушаалын байдал" гэж албан тушаалтны хэрэгжүүлж байгаа эрх үүрэгт хамааралгүй боловч тухайн албан тушаалтай холбоотой нэр хүнд, нөлөөг хэлнэ.</p> <p>"урвуулан ашиглах" гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар ойлгож хэрэглэнэ.</p> <p>"хүнд хор уршиг" гэж онц их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас хохирсон, хүний бие махбодид хүнд, эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учирсан, байгаль орчны тэнцэл алдагдсан, халдварт өвчин тархсан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зогссон зэргийг хэлнэ.</p> <p>"эрх мэдлээ хэтрүүлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 16 дугаар тогтоолын 5-д зааснаар ойлгоно.</p> <p>"хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгох бөгөөд албан</p>

		<p>тушаалтан бусдаар дамжуулан хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн нь үүнд нэгэн адил хамаарна.</p>
		<p>"Төрийн бус байгууллага" гэдгийг Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлд</p> <p>"аж ахуйн нэгж" гэдгийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5-д,</p> <p>"давуу байдал" гэдгийг Авлигын эсрэг хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т,</p> <p>"ашиг хонжоо" гэдгийг мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т тус тус зааснаар ойлгоно</p>
		<p>"эрх мэдлээ илтэд хэтрүүлэх" гэдгийг энэ тогтоолын 3-т зааснаар ойлгож хэрэглэнэ.</p>
		<p>"албан тушаалтны нэр барьж" гэдгийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид тодорхой албан тушаал эрхэлдэггүй этгээд тухайн байгууллагын албан тушаалтныг хууль бусаар төлөөлснийг ойлгоно.</p>
		<p>"албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх" гэж хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэр, гэрээний дагуу өөрт нь олгогдсон бүрэн эрх, үндсэн чиг үүргийг санаатайгаар огт биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй байхыг хэлнэ.</p> <p>"гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийх" гэдгийг албан тушаалтны хувьд өөрт нь олгогдоогүй эрх, үүргийг хэрэгжүүлснийг ойлгоно.</p> <p>"хээл хахууль" гэдэгт хууль бус зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд өгсөн эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрх, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үзүүлсэн аливаа ажил үйлчилгээ зэргийг хамааруулан үзнэ.</p>
		<p>"хясан боогдуулах" гэж тухайн хүнд тохиолдсон аливаа шаардлага, тулгамдсан хэрэгцээ, үүссэн нөхцөл байдлыг ашиглах замаар хээл хахууль зайлшгүй өгөх нөхцөл байдлыг зориудаар бий болгох, эсхүл хээл хахууль өгөхийг тулган шаардахыг хэлнэ.</p>
		<p>"илт хууль бус эд хөрөнгө" гэдэгт Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаас гадна зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл, түүнчлэн терроризмыг санхүүжүүлэх зорилгоор хуримтлуулсан, бий болгосон эд хөрөнгийг хамааруулан үзнэ.</p>
		<p>"хүнд хор уршиг" гэдгийг энэ тогтоолын 2-т зааснаар ойлгоно.</p>

			<p>"зориулалтын бусаар зарцуулсан" гэдгийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1-14.1.7-д заасан хориглосон үйл ажиллагаа явуулсныг ойлговол зохино.</p> <p>"зах зээлийн дунджаас дээгүүр үнэ" гэж зах зээлийн эрэлт нийлүүлэлт болон сонгон шалгаруулалтаар тогтсоноос илүү үнэ ханшийг хэлнэ.</p> <p>"зах зээлийн дунджаас доогуур үнэ" гэдгийг зах зээлийн эрэлт нийлүүлэлтээр тогтсоноос бага үнэ ханш гэж ойлгоно.</p> <p>"шаардлага хангаагүй" гэж заавал дагаж мөрдвөл зохих, хууль тогтоомж болон олон улсын буюу үндэсний стандартаар тодорхойлсон болзол, шалгуур үзүүлэлтэд нийцээгүй байхыг хэлнэ.</p>
2	2009.06.24	<p>Дугаар 22 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 17 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ</p>	<p>"бусад арга" гэдэгт эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулахаас гадна атаархал төрүүлэх, өс хонзон сануулах, уур хорслыг дэвэргэх, ятган үнэмшүүлэх, итгэмтгий гэнэн занг ашиглах зэргийг хамааруулж үзнэ.</p> <p>"хүүхдийг санаатай сольсон" гэж шунахай, өс хонзон болон хувийн бусад сэдэлтээр нэг хүүхдийг нөгөөгөөр нь орлуулсан буюу авсныг хэлнэ.</p> <p>"хууль бусаар үрчилсэн" гэдэгт хүүхэд үрчлэх, үрчлүүлэх нөхцөл, журмыг тодорхойлсон хууль тогтоомжийг дээрхи зорилгоор санаатай зөрчсөн үйлдлийг ойлгоно.</p> <p>"хаясан" гэж эцэг, эх нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1, Гэр бүлийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2, 26.3, 26.4-т заасан үүргээ гүйцэтгэхээс зайлсхийж, хүүхдээ бусдаар асрамжлуулах зорилгоор үлдээж явсныг хэлнэ.</p> <p>"төөрүүлсэн" гэдэгт дээр дурдсан зорилгоор хүүхдийг байнга оршин суудаг газар, орон байраа эргээд олох боломжгүй байршил, нөхцөлд орхиж явсан үйлдлийг ойлгоно.</p> <p>"шунахай зорилго" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 5.2-т зааснаар ойлгоно.</p> <p>"хараа хяналтгүй байлгасан" гэж Гэр бүлийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1-63.1.3-т заасан бага насны хүүхэд болон энэ зүйлийн 63.1.4-т заасан хүний талаар асран хамгаалагч нь хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлээгүй байхыг хэлнэ.</p>

		<p>"шаардлагатай тусламж" гэдэгт эдийн болон эдийн бус аливаа дэмжлэг туслалцаа хамаарна.</p>
		<p>"хайнга хандах" гэдэгт хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй байхыг ойлгоно.</p>
		<p>"шүүхийн шийдвэр биелүүлэхээс ноцтой зайлсхийсэн" гэдэгт шүүхийн шийдвэрээр үүрэг хүлээсэн этгээд түүнийг биелүүлэхээс татгалзах, оршин суугаа болон ажлын газрын хаягаа зориуд өөрчлөх, тэтгэлэг төлөх талаар санаачлага гаргахгүй байх, ажлын газрын хаяг болон цалин орлогоо нуун дарагдуулах, шүүхийн шийдвэр биелүүлэх талаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй зэргийг ойлгоно.</p>
		<p>"хүүхдийг албадан болон хүчээр хөдөлмөрлүүлсэн" гэж хүүхдийг өөрийнх нь хүсэл зоригоос гадуур, бие махбодийн болон сэтгэл санааны хүч хэрэглэх буюу хэрэглэхээр заналхийлж аливаа ажил үйлчилгээг төлбөргүй гүйцэтгүүлэхийг хэлнэ.</p>
		<p>Хуулийн 123 дугаар зүйлийн 123.1-д заасан "садар самууныг сурталчилсан" гэдгийг Садар самуун явдалтай тэмцэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно.</p>
		<p>"биеэ үнэлэхэд татан оролцуулсан" гэж шунахай болон хувийн бусад сэдэлтээр, энэ зүйл, хэсэгт заасан аргыг хэрэглэн, хохирогчийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.</p>
		<p>"биеэ үнэлэхэд татан оруулсан" гэдгийг дээрхитэй адилаар ойлгож хэрэглэнэ</p>
		<p>"эмнэлгийн бус нөхцөлд ... үр хөндсөн" гэдгийг Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д заасан эрүүл мэндийн байгууллагаас бусад газар энэхүү ажилбарыг хийснийг ойлгоно.</p>
		<p>"бусад хүнд хор уршиг" гэдэгт хохирогч хөгжлийн бэрхшээлтэй болсон, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, амиа хорлоход хүргэсэн, хүүхэд дахин төрүүлэх боломжгүй болгосон, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан зэргийг хамааруулан үзнэ</p>

			<p>"булш сүйтгэсэн" гэдэгт оршуулгын эсхүл өөр газарт байршуулсан талийгаачийн шарилын хөшөө, бунхан болон бусад зүйлийг санаатайгаар эвдсэн, гэмтээсэн, устгасан зэргийг ойлгоно.</p> <p>"тохуурхан даажигнаж" гэдэгт булшийг сүйтгэхдээ шарил, түүний үлдэц хэсгийг ил гаргаж хаях, элдэв хараал, өш хорслын үг, тэмдэгт бичиж үлдээх зэргийг хамааруулж үзнэ.</p> <p>"онц жигшүүртэй" гэж нийгмийн ёс суртахууны хэм хэмжээ, зан заншил, нийгэмд тогтож хэвшсэн ёс журмыг илтэд үл тоомсорлон шарилыг тасчих, шатаах, хэсэгчлэх, элдэв хэлбэрээр зураг авах, бичлэг хийх зэргээр ичгүүр сонжуургүй авирласныг хэлнэ.</p> <p>"хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.</p> <p>"хууран мэхлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т зааснаар буюу "үгээр болон үйлдлээр бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэх"-ийг ойлговол зохино.</p>
3	2009.05.22	<p>Дугаар 16 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 18 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ</p>	<p>"саад хийсэн" гэдэгт Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох хуульд тусгайлан заасан хориг, хязгаарлалтаас бусад тохиолдолд иргэний дээрхи эрхийг аливаа хэлбэрээр эдлүүлэхгүй байгаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/-г ойлгоно.</p> <p>"саад хийсэн" гэж хууль тогтоомжоор сонгууль болон ард нийтийн санал асуулгыг эрхлэн явуулах бүрэн эрх бүхий сонгуулийн төв, орон нутгийн байгууллагыг үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байдалд хүргэсэн, эсхүл хүндрэл учруулсан аливаа санаатай үйлдэл /эс үйлдэхүй/-г хэлнэ.</p> <p>"Хуурч мэхлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 3-т зааснаар буюу "үгээр болон үйлдлээр, бодит байдлыг гуйвуулах, нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар төөрөгдүүлэх"-ийг ойлгоно.</p> <p>"Санал худалдаж авах" гэдэгт иргэнийг сонгуульд оролцохоос татгалзуулах эсхүл нэр дэвшигчид санал өгүүлэхийн тулд мөнгө, эд хөрөнгө өгсөн, эсхүл эд хөрөнгийн давуу эрх олгосон, аливаа ажил үйлчилгээг төлбөргүй үзүүлсэн зэргийг хамааруулна.</p>

			<p>"бусад албан тушаалтан" гэдэгт нэр дэвшигчдийн болон сонгогчдын нэрсийн жагсаалт, нэр дэвшигчийн үнэмлэх, саналын хуудас, сонгогчийн үнэмлэх зэрэг сонгуулийн баримт бичгийг олгох үндэслэл болж буй анхан шатны бүртгэл, баримт бичиг, иргэний үнэмлэхийг энэ зүйл, заалтад дурдсан зорилгоор хуурамчаар үйлдсэн албан тушаалтныг хамааруулж ойлгоно.</p> <p>"саналаа чөлөөтэй илэрхийлэх эрхийг зөрчсөн" үйлдэл нь Монгол Улсын Үндсэн хууль болон холбогдох бусад хуулиар тогтоосон саналаа чөлөөтэй илэрхийлэх журмыг зөрчсөн, сонгуулийн хэсэгт саналаа тэмдэглэх тасалгаа, хаалтгүй байх, саналаа тэмдэглэхэд нь элдэв саад үүсгэх, тухайн сонгогчоос өөр гадны хүнийг дэргэд нь байлгах, саналаа хэрхэн өгч байгаа байдалд нь шууд хяналт тавих, саналын хайрцгийг битүүмжлэхгүй байх, саналын хуудсанд тэмдэглэл хийж чадахгүй сонгогчийн саналыг итгэмжлэгдээгүй хүнээр тэмдэглүүлэх, тухайн сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн даргын гарын үсэг, тэмдэггүй саналын хуудсаар санал өгүүлэх зэрэг хэлбэрээр илэрч болно.</p> <p>"Жагсаал, цуглаан зохион байгуулахад саад учруулсан" гэдэгт түүнийг хуулийн хүрээнд зохион байгуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, зохион байгуулах хороо, санаачлагчдын үйл ажиллагаанд эсхүл хуульд заасан журмын дагуу явагдаж байгаа жагсаал, цуглааны ажиллагаанд аливаа хэлбэрээр хориг, хязгаарлалт тогтоохыг ойлгоно.</p> <p>"ялгаварлан гадуурхсан" гэж жагсаал, цуглаанд оролцсоных нь төлөө иргэний төрөлхийн болон жам ёсны, түүнчлэн бусад эрхийг нь хориглох буюу хязгаарлахыг хэлнэ.</p> <p>"гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа" гэдэгт Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлээр хориглосон зүйл хамаарна.</p> <p>"иргэний захидал, харилцааны нууцын халдашгүй байдал" гэдгийг иргэний захидал, яриа, шуудангийн цахилгаан мэдээ, факс, дуут болон үсгэн, дүрст цахим мэдээ, баримт бичиг, биет зүйлийг илгээгч болон түүнийг хүлээн авагч хүний зөвшөөрөлгүйгээр бусад хүмүүст агуулгыг нь задлахыг хориглоно гэж ойлгоно.</p>
--	--	--	--

			<p>"албан тушаалын байдлаа урвуулж" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулна.</p> <p>"эрх мэдлээ хэтрүүлж" гэж хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхээс илүү эрх эдлэхийг хэлнэ.</p> <p>"тусгай техник, хэрэгсэл ашиглаж" гэдэгт нууцаар сонсох, харах, хувилж авах зэрэг зориулалт бүхий төхөөрөмжийг хууль бусаар хэрэглэснийг ойлгоно.</p> <p>"олон нийтэд тараасан" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 51 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгож хэрэглэнэ.</p> <p>"Орон байр" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2006 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 28 дугаар тогтоолын 1.9-д зааснаар ойлгоно.</p> <p>"нэвтрэх" гэж иргэний орон байранд зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар орохыг хэлнэ.</p> <p>"Дур мэдэн орж суух" гэдэгт иргэний орон байранд зөвшөөрөлгүйгээр, хууль бусаар нэвтрэн орж, түр болон бүр мөсөн суусныг ойлгоно.</p> <p>"Орон байрнаас гаргах" гэж эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан хуулийн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр иргэнийг орон байрнаас нь хууль бусаар, түр болон бүр мөсөн гаргасныг хэлнэ.</p> <p>"Нэгжлэг хийх" гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан үндэслэл, журмыг зөрчин нэгжлэгийг явуулж, орон байрны халдашгүй байдлыг зөрчсөнийг ойлгоно.</p> <p>"хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн журмыг сахиж хангуулах үүрэг бүхий этгээд" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийн дагуу энэ ажлыг шууд хариуцаж байгаа аливаа этгээд хамаарна.</p> <p>"бусад хүнд хор уршиг" гэдэгт тодорхой нутаг дэвсгэрт нийтээр өвчлөх, хордох, хүний бие махбодид хүнд гэмтэл эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учруулсан зэргийг ойлгоно.</p> <p>Хуулийн 140 дүгээр зүйлийн 140.1-д заасан "зохиогчийн эрх" нь Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан этгээдэд хамаарна.</p> <p>"...түүнд хамаарах бүтээл"-д мөн хуулийн 7 дугаар зүйлд заасан бүтээлүүдийг хамааруулж үзнэ.</p>
--	--	--	---

			<p>"шинэ бүтээл", "бүтээгдэхүүний загвар", "ашигтай загвар" гэдгийг Патентийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2, 3.1.3-т тус тус зааснаар ойлгоно.</p> <p>"ашиг олох зорилгоор" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1.2-т зааснаар ойлгож хэрэглэнэ.</p>
			<p>"шашны харгис үзэл номлол" гэдэгт шашнаар дамжуулан сурталчилж, тараасан үндэс угсаа, нийгмийн гарал, арьс өнгө, амьдралын хэв маяг, уламжлал, хэл соёл, өөр шашин шүтдэг эсхүл эс шүтдэгээр нь ялгаварлан гадуурхах, өөр хооронд нь дайсагналцуулах, аллага хядлага, амиа хорлох, цусан өшөө авах, хүний эрх, эрх чөлөөг хориглох, хязгаарлахад чиглэсэн аливаа үзлийг хамааруулна.</p>
			<p>"хүч хэрэглэж буюу хэрэглэхээр заналхийлэх" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.</p>
			<p>"эд мөнгөөр татах" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2008 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 16 дугаар тогтоолын 4-т заасны дагуу ойлгож хэрэглэнэ.</p>
4	2008.06.25	<p>Дугаар 29 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 22 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ</p>	<p>"Мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис" гэдгийг "Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай" хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д зааснаар ойлгоно.</p>
			<p>"Бэлтгэсэн" гэж байгальд ургадаг мансууруулах бодис бүхий ургамлыг түүж цуглуулсан, цэвэршүүлснээс гадна мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг дахин боловсруулж, хувирган өөрчилсөн, тун орцыг нэмэгдүүлсэн буюу багасгасан, бэлэн бүтээгдэхүүн, түүхий эдийн хэлбэрээр гаргаж авсан зэргийг хэлнэ.</p> <p>"Олж авсан" гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хуулийн 194 дүгээр зүйлийн 194.1-д зааснаас бусад аргаар өөрийн эзэмшлийнх болгоход чиглэгдсэн аливаа идэвхтэй үйлдэл хийхийг ойлгоно.</p> <p>"Хадгалсан" гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг биедээ авч явах, эсхүл орон байр, агуулах сав, түүнчлэн тусгайлан бэлтгэсэн нуувч зэрэг газарт байлгахыг хэлнэ.</p> <p>"Тээвэрлэсэн" гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр нэг газраас нөгөөд бүх төрлийн</p>

			<p>тээврийн хэрэгслээр ил буюу далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.</p> <p>"Илгээсэн" гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг шуудан буюу тээшийн илгээмжийн журмаар эсхүл бусад аргаар нэг газраас нөгөөд шилжүүлэх, уг ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлэхийг ойлгоно.</p> <p>"Борлуулсан" гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг худалдах, арилжих, солилцох, бэлэглэх эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцох (өрөнд өгөх г.м) зэргээр аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хэлнэ.</p> <p>"...завших..." гэдэгт санамсаргүй олдсон, түүнчлэн хадгалуулсан буюу бусад зорилгоор итгэмжлэн өгсөн мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хууль бусаар, үнэ төлбөргүй, өөрийн мэдэлд шилжүүлэн авахыг хэлнэ.</p> <p>"мэргэжлийн болон албан тушаалын байдлаа ашиглах" гэдэгт мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг бэлтгэх, үйлдвэрлэх, боловсруулах, хуваарилах, худалдах, хадгалах, бүртгэх, тээвэрлэх, устгах, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх, тус улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрүүлэх, мөн дээрх эм, бэлдмэл, бодисыг эмчилгээ, шинжилгээ, сургалт судалгааны зорилгоор ашиглах, хэрэглэх, түүнчлэн эдгээр ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны хийгээд бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.</p> <p>"...тарьсан..." гэдэгт Байгалийн ургамалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1-д зааснаар байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хамтран баталсан жагсаалтад дурьдсан мансууруулах бодис бүхий бүх төрлийн ургамлын үр цацах, суулгах, таримал ургамал ашиглах зэргээр өөрийн болон бусдын газарт тариалах ажиллагаа хийснийг ойлгох бөгөөд уг гэмт хэрэг энэхүү үйлдлийг хийснээр төгс үйлдэгдсэнд тооцогдоно.</p> <p>"...ургуулсан..." гэдэгт мансууруулах бодис бүхий ургамлын үр, суулгацыг тарьсны дараахь боловсрох хүртэл услах, бордох, хортон шавьж, хог ургамлыг устгах, тэдгээрээс хамгаалах зэргээр зориудаар тарьж ургуулахад чиглэгдсэн аливаа үйл ажиллагааг ойлгоно.</p>
--	--	--	---

			<p>"...хурааж авсан..." гэдэгт зориудаар тарьж ургуулсан мансууруулах бодис бүхий ургамлыг түүж цуглуулсан үйлдлийг ойлговол зохино.</p> <p>"Мансууруулах буюу сэтгэцэд нөлөөлөх бодисыг хэрэглэх байр байгуулсан" гэж мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодисыг хэрэглэх, бусдад хэрэглүүлэхийн тулд өөрийн буюу бусдын орон байрыг ашиглах, мөн тодорхой ажил үйлчилгээ, аж ахуйн нэгж, байгууллагын нэрээр халхавчлан тусгай газар бий болгосныг хэлнэ.</p> <p>"Мансууруулахаас бусад хүчтэй үйлчлэх болон хорт бодис" гэдгийг байгаль орчин, эрүүл мэнд, үйлдвэр худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан журамд зааснаар ойлгоно.</p>
5	2008.06.25	<p>Дугаар 30 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 23 ДУГААР БҮЛГИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ</p>	<p>"Хортой бодис" гэж агаар мандлыг бохирдуулах болон хүн, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд хортой нөлөө үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй биологийн ба химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.</p> <p>"Хориглосон арга, зэвсэг хэрэгсэл" гэдгийг Ан агнуурын тухай хуулийн 14 дүгээр зүйлд зааснаар ойлгоно.</p> <p>"Ховор ан амьтан"-ы жагсаалтыг Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6-д зааснаар Засгийн газар батлана.</p> <p>"Хориотой үед" гэдгийг Ан агнуурын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2-т тус тус тодорхойлсон хугацаанаас гадна уг зүйлийн 13.4, 13.5-д зааснаар төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацааг зөрчсөнийг ойлгоно.</p> <p>"Нэн ховор ан амьтан" гэдэгт Амьтны аймгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан амьтан хамаарна.</p> <p>"Аюултай хог хаягдал" гэдгийг Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1, 3.2-т тус тус зааснаар ойлгох бөгөөд мөн зүйлийн 3.3-т зааснаар аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн албадтай хамтран тогтооно.</p>

			<p>"Бусад хог хаягдал" гэж хэрэглээний болон үйлдвэрлэл, үйлчилгээний явцад үүсэн бий болж, цаашид ямар нэгэн зориулалтаар хэрэглэгдэхгүй болсон бөгөөд аюултай хог хаягдлын ангилал, зэрэглэлд ороогүй эд юмсыг хэлнэ.</p> <p>"Үйлдвэрлэлийн хортой хог хаягдал" гэдэгт энэ тогтоолын 4-т заасан аюултай хог хаягдлаас гадна Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2-т заасан хог хаягдлыг ойлгоно.</p> <p>"Биологийн болон химийн бодис" гэдэгт эдгээр бодисоос гадна тэдгээрийн нэгдлүүд нэгэн адил хамаарна.</p> <p>"Учирч болох байсан" гэдгийг тухайн нөхцөл байдалд ямар үр дагавар гарах байсныг шүүх хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн нотлох баримтын хэмжээнд үнэлж дүгнэнэ.</p> <p>"Ан амьтан, шувуу, загас олноор үхсэн болон бусад их хэмжээний хохирол учирсан" гэдэгт үхсэн ан амьтан, шувуу, загасны экологи, эдийн засгийн нийт үнэлгээ Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд тодорхойлсон хохирлын "их хэмжээн"-д хүрсэн байхаас гадна усны болон түүний орчмын ургамал, амьтан өвчлөх, загасны нөөц хомсдох, тэдгээрийн бүтэц өөрчлөгдөх (ховор үүлдрийн загасны нөөц багасах, хортой ба хэрэглээний бус үүлдэр бий болох г.м.) намагшсан буюу хужиршсан газар үүссэн зэргийн улмаас мөн "их хэмжээ"-ний хохирол учирсан байхыг ойлгоно.</p> <p>Нэн ховор ан амьтан, шувуу, загас хоёр буюу түүнээс дээш тоогоор үхсэнийг мөн ойлголтод хамааруулж үзнэ.</p> <p>"Ургамлын өвчин" гэдгийг Ургамал хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т зааснаар ойлгоно.</p> <p>"Хортон амьтан" гэдэгт Ургамал хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5, 3.1.6-д заасан шавьж, мэрэгчид тус тус хамаарна.</p> <p>"Хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ой" гэдгийг Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 9 дүгээр зүйлийн 9.1-д тус тус зааснаар ойлгоно.</p> <p>Мөн зүйл, хэсэгт заасан "Зохих зөвшөөрөлгүйгээр" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ашиглалтын бүсийн ойгоос хэрэглээний болон түлшний зориулалтаар мод</p>
--	--	--	---

			<p>бэлтгэх буюу ойн дагалт нөөцийг ашиглахдаа эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авч, тогтоосон төлбөр хураамжийг төлөөгүй байхыг хэлнэ.</p> <p>"Нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр эрхтэн"-ийг Байгалийн ургамалын тухай хуулийн хавсралт болон уг хуулийн 3 дугаар зүйлийн 4-т зааснаар Засгийн газраас батласан жагсаалтаар тодорхойлно.</p> <p>"Бусад хүнд хор уршиг" гэдэгт хүний бие махбодид хүнд гэмтэл учирсны улмаас байнгын тахир дутуу, сэтгэл мэдрэлийн эдгэршгүй өвчтэй болсон, эрхтнээсээ хагацсан, хараа, сонсголгүй болсон, хөдөлмөрийн чадвараа бүр мөсөн алдсан, хэд хэдэн хүний бие махбодид хүнд эсхүл хүндэвтэр гэмтэл учирсан зэргийг ойлгоно.</p> <p>"Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох" гэж эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлгүйгээр Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4, 4.1.5, 4.1.6-д тус тус заасан үйл ажиллагааг явуулахыг хэлнэ. Мөн зүйл, хэсэгт заасан "Үлэмж хэмжээний хохирол"-ыг зөвхөн байгаль орчин, түүний баялагт учруулсан байна.</p> <p>"Нөхөн сэргээлтийн ажил хийгээгүй" гэдэгт хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлд тус тус заасан үүргийг биелүүлээгүй байхыг ойлгоно.</p> <p>"Химийн хорт болон аюултай бодис" гэдгийг Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т тус тус зааснаар ойлгоно.</p> <p>"Хүнд хор уршиг" гэдэгт хүний бие махбодид хүнд гэмтэл эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учирсан, байгаль орчны тэнцэл алдагдаж, ан амьтан, загас, шувуу олноор үхсэн зэргийг хамааруулан ойлговол зохино.</p>
6	2008.03.26	<p>Дугаар 14 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 93 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ</p>	<p>"Хүчээр дарлагдсан" гэдэгт бие махбодийн болон сэтгэл санааны аливаа хүчирхийлэлд өртсөнийг ойлгоно.</p> <p>Энэ нь хүч хэрэглэн бие махбодид нь халдахаас гадна айлган сүрдүүлэх, заналхийлэх, хүсэл зоригийнх нь эсрэг үйлдэл хийлгэхээр албадах, тулган шаардах зэргээр үг яриа, үйл хөдлөл, үйлдлийн алинаар ч илэрч болно.</p>

		ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ, САНАА СЭТГЭЛ НЬ ГЭНЭТ ХҮЧТЭЙ ЦОЧРОН ДАВЧИДСАН ҮЕД БУСДЫГ САНААТАЙ АЛАХ ГЭМТ ХЭРГИЙГ ХҮНИЙГ САНААТАЙ АЛАХ ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАЖ, ЗӨВ ЗҮЙЛЧЛЭХ ТАЛААР	<p>"Хүндээр доромжлох" гэж нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг ичгүүр сонжуургүйгээр гутаасан үйлдлийг хэлнэ.</p> <p>Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрүүл мэнд, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ.</p> <p>"Хууль бус бусад үйлдэл" гэдэгт гэм буруутай этгээд буюу түүний ойр дотных нь хүмүүсийн эрх, ашиг сонирхлыг ноцтой зөрчсөн, хүчээр дарлах, хүндээр доромжлохоос бусад хууль бус үйлдлүүдийг хамааруулан ойлгоно. Тухайлбал, эд хөрөнгийг нь авахаар далайлган сүрдүүлэх, устгах гэмтээх, хүний төрөлхийн болон жам ёсны эрхийг хязгаарлах, хориглох, дураараа аашлах, гүтгэх гэх мэт.</p> <p>"Ойр дотны хүмүүс" гэдэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.11-д заасан гэр бүлийн гишүүд хамаарна.</p> <p>"Хүнд хор уршиг учирсан" гэдэгт хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас эд хөрөнгийн хувьд хохирол учирсан, гэм буруутай этгээд болон түүний гэр бүлийн гишүүд нь сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, бие эрхтэнд нь хүнд гэмтэл учирсан буюу амь нас хохирсон зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.</p> <p>"Хүнд хор уршиг учирч болох байсан" гэдгийг хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас тухайн нөхцөл байдалд ямар үр дагавар гарах байсныг шүүх хэрэгт авагдсан болон шүүх хуралдаанаар хянан хэлэлцсэн нотлох баримтын хэмжээнд үнэлж дүгнэнэ.</p> <p>"Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчидсан" гэж хохирогчийн хууль бус үйлдлийн улмаас сэтгэл санааны гэнэтийн цочролд хоромхон зуур автаж, сэтгэхүйн хэвийн байдал алдагдан, өөрийн үйл ажиллагааг удирдан жолоодох, өөртөө хяналт тавих чадваргүй болсон байдлыг хэлнэ.</p>
7	2008.03.26	Дугаар 13 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 146 ДУГААР ЗҮЙЛД	<p>"Булаах" гэдэгт бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр авсан, өөрөөр хэлбэл хохирогчид бие махбодийн болон сэтгэл санааны ямар нэг хүч хэрэглээгүй, хэрэглэхээр заналхийлээгүй, зөвхөн ил аргаар эд хөрөнгийг нь салган авч тэр даруйдаа хохирогчоос зугтан зайлсхийсэн шинжтэй үйлдэл хамаарна.</p>

		ЗААСАН "БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ БУЛААХ" ГЭМТ ХЭРГИЙГ 147 ДУГААР ЗҮЙЛД ЗААСАН "БУСДЫН ЭД ХӨРӨНГИЙГ ДЭЭРЭМДЭХ" ГЭМТ ХЭРГЭЭС ЯЛГАЖ, ЗӨВ ЗҮЙЛЧЛЭХЭД АНХААРАХ ЗАРИМ АСУУДЛЫН ТАЛААР	<p>"Дээрэмдэх" гэдэгт бусдын эд хөрөнгийг хууль бусаар авахад саад болж байгаа аливаа этгээд (өмчлөгч буюу эзэмшигч, итгэмжлэгдэн хариуцсан болон хамгаалах үүрэг бүхий этгээд гэх мэт) рүү амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж довтолсон аливаа идэвхтэй үйлдлийг ойлгоно.</p> <p>"Довтолсон" гэж бусдын эд хөрөнгийг өөрийн өмчлөлд авах зорилгоор илээр эсхүл гэнэдүүлэн (араас нь цохих, хоолой боох гэх мэт) өөр этгээд рүү хүч хэрэглэн халдсаныг хэлнэ. Энэхүү халдлагад бие махбодийн хүчирхийллээс гадна хохирогчийн сэтгэцийн үйл ажиллагааг алдагдуулах, хордуулах буюу мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэл, бодис зэргийг илээр болон нууцаар хэрэглэснийг хамааруулж үзнэ.</p> <p>"Амь биед нь аюултайгаар хүч хэрэглэж" гэдэгт хохирогчийн эсэргүүцлийг дарахад чиглэгдсэн бие махбодийн хүчирхийллийн аливаа үйлдэл хийснийг ойлгоно.</p> <p>Хүч хэрэглэсэн тухайн үйлдлийн улмаас бусдын бие махбодид хор уршиг бодитойгоор учраагүй боловч хүч хэрэглэсэн арга нь (хоолой боох, хохирогчийн толгойг усанд удаан дүрэх, өндөр дээрээс түлхэх гэх мэт) хохирогчийн амь биед нь аюултай нөхцөл байдал бий болгохоор байсан бол дээрхи ойлголтонд хамааруулж үзнэ. Түүнчлэн гэмт халдлагын улмаас хохирогчийн бие махбодид хөнгөн, хүндэвтэр, хүнд гэмтэл учирсан бол "амь биед нь аюултайгаар хүч хэрэглэсэн" гэдэгт хамаарна.</p> <p>"Хүч хэрэглэхээр заналхийлж" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгож хэрэглэнэ.</p>
8	2008.03.26	Дугаар 12 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 113 ДУГААР ЗҮЙЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ	<p>"Хүн худалдаалах" гэдэгт тодорхой төлбөртэйгөөр (мөнгө авах, эд хөрөнгө болон түүнийг өмчлөх эрхээр солилцох г.м) эсхүл ямар нэгэн үүргийн гүйцэтгэлд тооцож (өрөнд өгөх г.м) хүнийг бусад хүмүүсийн мэдэлд бүр мөсөн буюу тодорхой хугацаагаар шилжүүлэхийг ойлгоно.</p> <p>"Ашиг олох зорилгоор" гэж хүн худалдаалах замаар өөртөө болон бусад этгээдэд эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус ашигтай байдал, орлого бий болгохыг хэлнэ.</p> <p>"Хүч хэрэглэсэн, хүч хэрэглэхээр заналхийлсэн" гэдгийг Улсын Дээд шүүхийн 2007 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 41 дүгээр тогтоолын 1.4-т зааснаар ойлгоно.</p>

		<p>ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ</p>	<p>"Хууран мэхэлсэн" гэж үгээр буюу үйлдлээр, бодит байдлыг нуун дарагдуулах, эсхүл зохиомол байдлыг зориудаар бий болгох замаар бусдыг төөрөгдүүлэхийг хэлнэ. Энэ нь гадаад улсад ажиллах, суралцах, аялах, гэрлэхэд зуучлах зэргээр худал амлах хэлбэрээр илэрнэ.</p> <p>"Эмзэг байдлыг нь далимдуулсан" гэдэгт хохирогчийн эдийн засаг, эрүүл мэнд болон хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, түүнчлэн амьдрал ахуйн бусад хүнд байдал зэргийг ашигласан байхыг ойлгоно.</p> <p>"Элсүүлсэн" гэж хүнийг худалдаалах зорилгоор тухайн болон бусад этгээдийг айлган сүрдүүлэх, тулган шаардах, ятгах замаар гэмт ажиллагааны оролцогч болгох аливаа үйлдлийг хэлнэ. Хүн худалдаалах гэмт хэргийг үйлдэхдээ бусдыг татан оролцуулахаас гадна хохирогчийн биеэ хамгаалах чадваргүй болон эрхшээлдээ байгаа байдал зэргийг далимдуулан зөвшөөрүүлэх явдал нь энэ ойлголтод нэгэн адил хамаарна.</p> <p>"Тээвэрлэсэн" гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг нэг газраас нөгөөд бүх төрлийн тээврийн хэрэгслээр ил болон далд хэлбэрээр зөөвөрлөхөөс гадна уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг ойлгоно.</p> <p>"Дамжуулсан" гэж хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд хүнийг гуравдагч улсын нутаг дэвсгэрээр дамжуулан хил нэвтрүүлэх, нэг этгээдээс нөгөөд хүнийг шилжүүлэх болон уг ажиллагаанд бүх талын дэмжлэг тусалцаа үзүүлэхийг хэлнэ.</p> <p>"Орогнуулсан" гэдэгт хүн худалдаалж байгааг мэдсэн этгээд худалдаалагдаж буй хүнийг хүлээн авах этгээдэд шилжих хүртэл түр хугацаагаар өөрийн, эсхүл бусдын орон байранд хяналттай болон хяналтгүйгээр нуугдуулан байрлуулахыг ойлгоно.</p> <p>"Хүлээн авсан" гэж худалдаалагдсан хүнийг өөрийн мэдэлд байлгаж, ашиглахаар шилжүүлэн авахыг ойлгоно.</p> <p>"Эрх мэдлээ урвуулан ашиглах" гэдэгт хууль тогтоомж буюу эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийн дагуу өөрт нь олгогдсон албаны болон бусад бүрэн эрхийг санаатайгаар харш ашигласан явдлыг хамааруулж үзнэ.</p> <p>"Эрхшээлдээ байгаа" гэдэгт эд хөрөнгийн болон бусад нөхцөл байдлын улмаас тухайн этгээдээс хараат байхыг ойлгоно.</p>
--	--	------------------------------------	---

			<p>"Хил давуулан" гэдэгт хүнийг худалдаалахын тулд улсын хилийг нууцаар, эсхүл хуурамч буюу хууль ёсоор олж авсан баримт бичиг ашиглан илээр нэвтрүүлэхийн аль аль нь хамаарна.</p> <p>"Хүнд хор уршиг учирсан" гэдэгт хүнийг худалдаалахтай шууд холбоотойгоор амь нас нь хохирсон, амиа хорлоход хүргэсэн, бие махбодид нь хүнд гэмтэл учирсан, сэтгэцийн болон бусад хүнд өвчнөөр өвчилсөн, түүнчлэн эд хөрөнгийн хувьд хохирол учирсан зэрэг үр дагавар бий болсныг ойлгоно.</p> <p>"Биеийг нь үнэлүүлэх" гэж хохирогчийн хүсэл зоригоос гадуур түүнийг бусадтай бэлгийн харьцаанд төлбөртэй оруулахыг хэлнэ.</p> <p>"Бэлгийн хүчирхийлэлд оруулах" гэдэгт биеийг нь үнэлүүлэхээс гадна тулган шаардах, хүч хэрэглэх буюу хүч хэрэглэхээр заналхийлж садар самууныг сурталчлахад татаж оруулсан, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан аливаа үйлдэл хийсэн зэргийг ойлгоно.</p> <p>Өрийн дарамтад оруулах зэргээр биеийг нь үнэлүүлсэн болон бусад хэлбэрээр бэлгийн хүчирхийлэлд оруулсан бол үүнд нэгэн адил хамаарна.</p> <p>"Албадан хөдөлмөр хийлгэх" гэдэгт хүний хүсэл зоригоос гадуур түүгээр аливаа ажил үйлчилгээг төлбөргүйгээр гүйцэтгүүлэхийг хэлнэ.</p> <p>"Боолчлох" гэдэгт эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус өмчлөх эрхэд хамаарах бүх, эсхүл зарим эрхийг хүн дээр хэрэгжүүлж, түүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлахыг ойлгоно.</p> <p>"Боолчлолтой ижил төстэй нөхцөлд байлгах" гэж хуульд харшилсан зан заншил, уламжлал, шашин шүтлэг зэрэгтэй холбоотойгоор хүний төрөлхийн болон жам ёсны бүх эрхийг хориглох буюу хязгаарлах явдлыг хэлнэ.</p> <p>"Эд эрхтнийг нь авч ашиглах" гэдэгт хүний цус, нөхөн үржихүйн эд (өндгөвч, төмсөг, өндгөн эс, сүн, ураг)-ээс бусад эд эрхтнийг ашиг олох зорилгоор, хууль бусаар авсан үйлдлийг хамааруулж үзнэ.</p>
9	2007.12.21	Дугаар 51 ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН 139	"Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээлэл..." гэдэгт тухайн этгээдийн өөрт нь болон бусдад холбоотой тодорхой асуудал, сэдвийн дагуу нийтэд мэдээлэхээр сэтгүүлчээс бэлтгэсэн аливаа бүтээлийг ойлгоно.

